

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр, Мягмар гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 40
1.	<i>Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/</i>	5 – 39
2.	<i>Дэд хорооны даргыг сонгох тухай асуудал</i>	39 – 40

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 10 дугаар сарын 07-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 22 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Т.Аубакир, Р.Батболд, Ж.Батсуурь, Х.Болормаа, Ж.Ганбаатар, Ц.Даваасүрэн, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, Г.Тэмүүлэн.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, Р.Ринчинбазар, А.Энхбат, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын Санхүүгийн аудитын менежер С.Нацагдорж, Гүйцэтгэлийн аудитын газрын менежер Ю.Энхтуяа, Нийцлийн аудитын газрын менежер Э.Баттогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын шинжээч Ж.Өлзийсайхан, Сангийн яамны Татварын бодлогын газрын ахлах мэргэжилтэн Т.Бат-Оргил, мөн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн Э.Цолмон, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн Р.Хангал, О.Гантулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, Бат.Баярмаа, референт С.Тэгшжаргал, Г.Нарантуяа, С.Төрмөнх нар байлцав.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Ж.Алдаржавхлан, Ж.Баясгалан, Ч.Номин, Д.Үүрийнтуяа, Ж.Батжаргал, С.Эрдэнэбат, Да.Цогтбаатар, Б.Мөнхсоёл нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлэв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Дэд хорооны даргыг сонгох тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, С.Төрмөнх нар байлцав.

Байнгын хорооны дарга Х.Ганхуяг Дэд хорооны даргыг сонгох тухай асуудлыг танилцуулав.

Уг асуудлыг дараагийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхээр тогтов.

Уг асуудлыг 17 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 28 минут үргэлжилж, 29 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 62.1 хувийн ирцтэйгээр 17 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.ГАНХУЯГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
16 цаг 22 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Ганхуяг: Х.Ганхуяг: Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 51.7 хувьтай ирц бүрдсэн тул Төсвийн байнгын хорооны 2025 оны 10 сарын 07-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя.

Нэг. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийнэ.

Хоёр. “Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай” асуудал гээд хоёр асуудал байна.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн байхгүй байна.

Манай Байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу төсвийн төслийн нэг, хоёр дахь хэлэлцүүлгийг олон нийтийн хэлэлцүүлэг хийсэн байгаа. 6 цуврал хэлэлцүүлгийг хийсэн. Үүнд:

- ▶ Нэгд. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх боломж, эрсдэл.
- ▶ Хоёрт. Боловсролын салбарын 2026 оны төсөв.
- ▶ Гуравт. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төслүүд.
- ▶ Дөрөвт. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын 2026 оны төсвийн орлого бүрдүүлэлт.
- ▶ Тав. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын 2026 оны төсөв гээд 6 сэдвийн хүрээнд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Та бүхэнд энэ хэлэлцүүлгийн талаарх мэдээллийг бүгдийг нь хэвлэмэл материалаар тараасан байгаа.

Ер нь томьёолоод дүгнэвэл эрүүл мэнд, боловсролын салбарт гүйцэтгэл дээр суурилсан санхүүжилтийн шинэчлэлийг эрчимжүүлэх талаар саналууд нэлээн яригдсан.

Боловсролын салбарт багш нарын цалин болон ахмад настны тэтгэврийн хэмжээг инфляцад уялдуулан нэмэгдүүлэх асуудлыг ярьсан байгаа. Саналууд гарч ирсэн байгаа.

Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг урт хугацааны хөгжлийн зорилттой уялдуулах асуудлыг иргэд, оролцогч нар хөндсөн байгаа.

Гадаадын зээл, тусламжийн үр дүнг сайтар үнэлж, өрийн тогтвортой байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх талаар бас саналууд дурдагдсан.

Татварын шинэчлэлээр иргэд, аж ахуйн нэгжүүдийн татварын дэмжлэгийг оновчтой болгох, өрхийн орлогыг дэмжих зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж иргэд, оролцогч нараас бол мэдээлэл ирсэн.

Улсын Их Хурлын 2026 оны төсвийн тухай хуулиудыг хэлэлцэж байгаа үед манай Байнгын хорооноос зохион байгуулсан хэлэлцүүлгүүдийн товч мэдээлэл, гарсан саналуудыг нэгтгэн чуулганы нэгдсэн хуралдааны төсвийн төслийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг танилцуулах, мөн хэлэлцүүлэгт оролцогчдоос гарсан санал, дүгнэлтүүдийг холбогдох төрийн захиргааны байгууллагууд болон Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлэхээр санал болгож байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай,
Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай
хуулийн төслүүд
/Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хоёр дахь хэлэлцүүлэг/**

Нэг. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг Та бүхэнд танилцуулъя.

Ням-Осорын Учрал Тэргүүн Шадар сайд. Дуудаарай. Болдын Жавхлан Сангийн сайд, Л.Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Р.Ринчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, А.Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, З.Цэдэнжав Монгол Улсын ерөнхий аудиторов орлогч, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ч.Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга, Даринчулууны Эрдэнэтуяа Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Сүхбаатарын Нацагдорж Үндэсний аудитын Санхүүгийн аудитын менежер, Юрагийн Энхтуяа Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын менежер, Энх-Амгалангийн Баттогтох Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын менежер, Жамбалбавуугийн Өлзийсайхан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын шинжээч, Т.Бат-Оргил Сангийн яамны Татварын бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Э.Цолмон Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Р.Хангал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн, Очирхуягийн Гантулга Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн нарийн бүрэлдэхүүнтэй байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.3-д Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд төсвийн төслийн хэлэлцүүлэг хийсэн талаар танилцуулга боловсруулж Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын Байнгын хороод 2025 оны 9 дүгээр сарын 29, 30, 10 дугаар сарын 01-ний өдрүүдийн хуралдаанаар төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг хийж, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд ирүүлснийг Та бүхэнд тараасан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 2-т Байнгын хорооны гишүүд тухайн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлнэ гэж заасны дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн төслүүдийн талаар асуулт асуух гишүүн байна уу? Би сүүлд нь асуултаа асууя. Ж.Батжаргал гишүүнээр тасалъя.

Далайн Батбаяр гишүүн.

Д.Батбаяр: Энэ өдрийн мэндийг хүргэе.

төсвийн хоёр дахь хэлэлцүүлэг явагдаж байна. Тэгээд 2026 оны төсвийн асуудал яригдаж байна.

Тэгээд саяхан Хавдар судлалын эмнэлэг дээр очиж 2 хоног хүн сахисан. Тэгээд Хавдар судлалын эмнэлэг бол маш хүнд байдалд байна. Сахиж байгаа хүмүүс нь ч, эмчлүүлж байгаа хүмүүс нь ч гэсэн бүгдээрээ нийлээд орсон. Тэнд эмчилгээ хийхэд маш хүнд нөхцөлтэй байж байгааг харсан.

Тэгээд бид өнгөрсөн жил ярьж ярьж байгаад Хавдар судлалын үндэсний төв шинээр байгуулъя гэдэг байдлаар шийдлийг нь гаргаад, газрыг нь Сонгинохайрхан шинээр олгохоор болоод явж байсан сайхан цаг бий.

Тэгээд түүнээс хойш бараг жил өнгөрсөн байна. Тэгээд одоо 2026 оны төсвийн төсөл дээр орж ирж байгаа хөрөнгө оруулалт хэсэг дээр хавсралт дээр нь ороод ирсэн байна л даа. Яаж орж ирсэн бэ гэхээр Хавдар судлал үндэсний төв, 2 дугаар цогцолборын А, Ц блокийн барилга, гадна шугам сүлжээ, Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг гээд. 40 тэрбум 523 сая төгрөгийн төсөл ороод ирсэн.

Тэгсэн энэ төсөл маань өөрөө юунд орж ирсэн бэ гэхээр нөгөө төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний жагсаалтад ороод ирсэн. Бүтэн жилийн дотор зураг, төсөл нь гараагүй. Тэгсэн мөртлөө яаж ийж байгаад мөнгийг нь суулгая. Тэгээд дараа нь болъё гэдэг байдлаар орж ирж байна. Тэгээд энэ бол зарчимд нийцэхгүй асуудал.

Яагаад гэвэл би тойрогтоо нэлээн хэдэн асуудлуудыг тавьж байсан. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй аливаа төсөл, арга хэмжээнүүдийг энэ жагсаалтад оруулахгүй байх ёстой, ирэх онд суулгахгүй байх ёстой гэсэн байр суурьтай байгаа юм.

Хэдийгээр асуудал маань өөрөө ноцтой боловч энд ороод ирсэн байна.

Тэгэхээр миний асуулт ийм байна.

- ▶ Энэ хариуцсан улсууд нь зураг, төслийг нь хийлгэхгүй бүтэн жил юу болсон юм бэ?
- ▶ Яагаад зураг, төслийг нь хийлгэж амжаагүй юм бэ?

Тэгээд энэ дээр Сангийн яамны холбогдох албан тушаалтнууд юу гэж бодож байгаад оруулж ирсэн юм бэ? Зураг, төслийг нь хэзээ оруулъя гэж оруулж ирсэн юм бэ? гэдэг нэгдүгээр асуулт байна.

Хоёрдугаарт нь, ер нь шаардлага хангаагүй нийтдээ 36 төсөл байна. Тийм ээ? Энэ олон төслүүдийг ер нь яах юм бэ? Нийт төсөвлөгдсөнөөрөө 391.0 тэрбум. Энэ жилд санхүүжих дүн нь 196 тэрбум 507.9 сая төгрөг гэсэн нийт дүнтэй төслүүд, үнийн дүн ороод ирсэн явж байна.

Тэгэхээр нөгөө хуулиа яах юм бэ? Зураг, төслийг нь төсвийн шаардлагыг яаж хойноос нь хангуулж явах юм уу гэдэг хоёрдугаар асуулт байгаа.

Х.Ганхуяг: 1 минут нэмээд өгье.

Д.Батбаяр: Гуравдугаарт нь, аливаа улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төслүүдийг 3 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх ёстой. Энэ дээр нийтдээ 76 төсөл. Бүгд дээр нь 10, 10, 10-аас 20 хувь тусгасан 76 төсөл байна. Энэ бол 3 жилийн хугацаанд гүйцэтгэж хийж дуусгах ямар ч боломж байхгүй. Нийтдээ 1 их наяд 573.0 тэрбум төгрөг гээд 75 төсөл байна.

Энэ 5 төслийн талаар тайлбарлаад хэлээд өгөөч.

Бүгдийг нь амлуулаад, амлуулаад орхиод явах юм уу? Сүүлийн 2 жилд нь бүгдийг нь хийж гүйцэтгэнэ гэж харж байгаа юм уу? Баярлалаа.

Х.Ганхуяг: Хэн хариулах юм? Ж.Ганбат дарга хариулах уу?

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя.

Хавдар судлалын эмнэлгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2.4 тэрбум төгрөгөөр боловсруулсан. Тэгээд хавдар бол бодлогын бүх бичиг баримтад нь орсон. Бодлогын хүрээнд төлөвлөсөн ажил байгаа.

Тэгэхээр үнэхээр Хавдар судлалын эмнэлгийн асуудал яг таны хэлж байгаа тэр бодит байдал ийм байгаа.

Зүгээр би энэ дээр нэг юм нэмэлтээр хэлэхэд яг бодит байдал дээр үнэхээр салбарын яамдын асуудал үнэхээр хүнд байгаа. Та одоо энэ оны төсвийн тодотгол дээр бид хэд энэ 2025 оны анхны батлагдсан төсөв дээр Эрүүл мэндийн яаман дээр бид 60.0 тэрбумын тоног төхөөрөмж Улсын Их Хурлаар батлаад өгч байгаа. Түүнийгээ ашиглаж чадахгүй сая хураалгасан.

Үнэхээр энэ дээр төслийн бэлэн байдлыг захиалагч буюу салбарын яамд хангуулах л ёстой.

Бид төсвөө 11 сарын 15 гэж батлагдахад зураг төсөвтэй, ТЭЗҮ-тэй, бүх юм нь бэлэн төсөв л батлагдах ёстой. Хуулиараа. Төсөв батлагдлаа. Маргаашаас эхлээд худалдан авалтыгаа зарлаад ажиллах бүрэн бололцоотой. Энэ дээр үнэхээр хариуцлагын асуудал байгаа учраас үүнийг бид хуулийг хэрэгжүүлэх талд нь Сангийн яамны зүгээс Засгийн тогтоолыг удаа дараа

гаргуулдаг, шахдаг, ийм байдлаар ажилладаг. Үнэхээр хүндрэлтэй асуудлууд үүсээд байгаа. Энэ тал дээр аудитын байгууллага асуудал, юмнууд хэлэх байх гэж бодож байна.

Нөгөө талдаа зургийн байгууллагуудын чадамжийн асуудал, хүчин чадал, чадавхын асуудлууд байна. Бодитоор. Үнэхээр шаардлага хангаж боловсруулах гээд бэрхшээлтэй асуудал. Зургийг дахин дахин боловсруулдаг. Нэмэлт байдлаар ажлууд яг ажил гүйцэтгэж байх явцад гаргадаг асуудлууд байна.

Сүүлийн асуултын хувьд шинээр эхлэх барилга, байгууламж. Төсвийн тухай хуулийн 29.3.5 дээр шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож 3 жилд багтааж санхүүжүүлж дуусгах гээд. Энэ бол уг нь төсвийн хууль дээр өмнө нь энэ заалт орохоос өмнө амсуулах байдлаар тавиад урт хугацаанд сунжраад дуусдаггүй байсныг л уг нь зогсоох гэж энэ заалтыг оруулж ирж уг нь яг энэ 3 жилийн хугацаанд дуусгах гэдэг байдлаар л жоохон сахилга батаа сайжруулах байдлаар оруулсан заалт байгаа.

Үнэхээр ажил нь сайн яваад, худалдан авалтаа амжилттай зохион байгуулаад, шалгарсан компани нь ажлаа сайн гүйцэтгэж байвал бид заавал 3 жилийг хүлээхгүйгээр аль болох төсөв дээр санхүүжилтийг нь бүрэн тавиад, богино хугацаанд дуусгах тал дээр бид шилжиж байгаа объектуудыг нэн түрүүнд дуусгая гэдэг бодлогыг Засгийн газар, Сангийн яамнаас онцгой анхаарч байгаа.

Х.Ганхуяг: Дахиад нэг тодруулж болно. Д.Батбаяр гишүүний микрофоныг.

Д.Батбаяр: Тэгэхээр Ж.Ганбат дарга аа, ингэж асуугаад байгаа юм л даа.

Төсвийн төслийг боловсруулахдаа яриад байгаа, яригдаад байгаа хуульд нийцүүлэх гэдэг энэ зүйлээ яагаад мартаад байгаа юм. Та хэд. Одоо энэ дээр бүс нутгийн найдвартай цахилгаан, дулаан хангамж 2 дугаар үе гээд 23.0 тэрбум төгрөг байхад энэ жил зөвхөн 2.0 тэрбумыг нь тавьж байгаа байхгүй юу. Тэгээд үлдсэн 19 тэрбумыг нь дараагийн 2 жилд нь тавих юм уу? Энэ бол нийт гүйцэтгэлийнх нь 10 хувьд л хүрэхээр мөнгийг нь тавьсан байгаа байхгүй юу.

Тэгэхээр хуульд нийцүүлэх тал дээр нь ямар бодлого баримжаа баримталж байгаа юм бэ л гэдэг асуултыг асуугаад байгаа юм. Нэгэнт энд хариуцсан сайд нар нь байхгүй байгаа учраас. Та дахиад хариулаад өгөөч.

Х.Ганхуяг: Ж.Ганбат даргын микрофоныг өгье.

Ж.Ганбат: Бид Улсын Их Хуралд өргөн барьсан төсөв дээр таны хэлдгээр тэр хуулийн шаардлагууд уг нь бүрэн хангуулаад л төсвийг боловсруулж байгаа шүү дээ. Одоо яг үнэхээр хуулийн шаардлагад заасан.

Манай боловсруулсан төсвийг дараа нь Үндэсний аудитын газар хуульд нийцэж байна уу, үгүй юу гэдэг дээр нь аудит хийж байгаа.

Бид үнэхээр түүн дээр хуулийн шаардлага бүрэн хангуулаад л ингэсэн. Одоо яг тийм шаардлага хангаагүй юм байхгүй.

Х.Ганхуяг: Аудит нэмээд тайлбарла, гүйцээгээд хариул. 5 номерын микрофон өгье.

Д.Энхболд: Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд.

Д.Батбаяр гишүүний асуултад хариулъя.

Саяын ярьж байгаа Хавдар судлалын үндэсний төвийн 2 дугаар цогцолборын А, Ц блокийн барилга, гадна шугам сүлжээ, Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг төсөл, арга хэмжээ бол аудитаар төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний тоонд орсон байгаа. Зураг, төсөл, төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй 5 арга хэмжээний нэг нь байгаа.

Хоёр дахь асуудал дээр бол тухайн жилийн санхүүжилтийг хэрэгжүүлэх хугацаанд уялдуулж төлөвлөөгүй төсөл, арга хэмжээний 75 арга хэмжээ аудитаар гарсан. Төсөвлөлтийн хуваарийг 3 жилийн хугацаанд тэнцүү хуваарилсан байх гэдэг шаардлагыг хангаагүй 75 арга хэмжээнд сая... /минут дуусав/

Х.Ганхуяг: Хариулаад болсон юм уу? Нэмээд хариул, гүйцээгээд хариул.

Д.Энхболд: Саяын бүс нутгийн найдвартай цахилгаан, дулаан хангамж 2 дугаар үе шат, улсын хэмжээнд гэдэг төсөл, арга хэмжээний санхүүжилтийн 10 хувийг тавьсан байгаа.

Тэгэхээр Үндэсний аудитын газрын жил болгоны төсвийн төсөл дээр өгдөг дүгнэлт, зөвлөмжийн хувьд төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөхгүй байх гэдэг зөвлөмжийг жил болгон өгч байгаа. Өнгөрсөн жилтэй харьцуулахад харьцангуй шаардлага хангаагүй арга хэмжээ буурсан.

Өмнөх жил 145 байсан бол энэ жил 5 төсөвлөлтийн шаардлага хангаагүй арга хэмжээг төлөвлөсөн байгаа.

Х.Ганхуяг: 6 номерын микрофон өгье.

Ж.Дэлгэржаргал: Д.Батбаяр гишүүний асуултад хариулъя. Сангийн яам. Ж.Дэлгэржаргал.

Бүс нутгийн найдвартай байдлыг хангах 2 дугаар үе шатын хувьд яг 3 жил буюу 2026-2028, төсөвт өртөг 78.0 тэрбум, санхүүжих нь 23.0 байгаа.

Аудитын дүгнэлт болохоор санхүүжих дүнгийн харьцаа буюу 10 хувийг дутуу тавьсан байна гэж үзээд байгаа. Бид нарын хувьд яг хэрэгжих боломж, хуулийн заалтын хүрээндээ 3 жил хэрэгжихээр төлөвлөөд, дээрээс нь шинэ хөрөнгө оруулалтын хувьд эхний жил худалдан авах ажиллагаанаас хамаараад манай хийсэн судалгаагаар ерөнхийдөө 30 хувийг 3 тэнцүү хуваасан төслүүдийн ихэнх нь бүрэн авч чадахгүй судалгаанууд байгаа.

Тийм учраас зарим санхүүжилт, өндөр дүнтэй дүнгүүдээс бид байх ёстой дүнгээс нь 10 хувийг дутуу гэж байгаа. Тэгэхээр 10 хувийг тавьсан биш, тавих ёстой дүнгээсээ 10 хувь дутуу хуваарилсан байна гэж аудит дүгнэсэн.

Х.Ганхуяг: Ж.Алдаржавхлан гишүүн асуултаа асууя.

Ж.Алдаржавхлан: Асуулт асууя. Би тойрогтойгоо холбоотой асуудлыг Байнгын хороон дээр ярья гэж бодож байгаа юм.

“Солонго-1, 2” хороолол гээд төсөл явж байгаа шүү дээ. Төсвөөс санхүүжиж байгаа. Тэр төсвийн санхүүжилтэд 2025, 2026 онд хэдэн тэрбум төгрөг тавьж байгаа вэ? Нэгдүгээрт, үүнийг хэлж өгөөч ээ.

Хоёрдугаарт нь, 7 дугаар сард төсөвт санал авахад би Хан-Уул дүүрэгт хамгийн хэрэгцээтэй байгаа улсын сургууль, цэцэрлэгийн тоог гаргаад байршлыг нь заагаад Сангийн яаманд явуулсан. Үүнээс суусан уу? Суугаагүй бол яагаад суугаагүй вэ? Зарим аймаг, дүүрэгт хоёр гурваараа суусан байна лээ. Хэнд нь суулгаад, хэнд нь суулгаагүй вэ? Үүнийг хариулж өгөөрэй.

Гуравдугаарт нь, хуримтлалын сангаас 2024 онд ипотекийн зээлийн санхүүжилт нь 467.0 тэрбум төгрөг санхүүжүүлсэн байна лээ. 2026 онд хэдийг санхүүжүүлэх вэ? Төлөвлөж байна вэ? Хуримтлалын сангаас.

Одоо энэ ипотекийн зээл би чинь очер дугаар, авлига бүр хэрээс хэтэрсэн байна лээ. Би одоо Эдийн засгийн байнгын хорооноос ипотекийн зээлийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийг ахлаад ажиллаж байгаа. Сангийн яам ерөөсөө огт оролцохгүй шахуу байгаа. Хэзээ энэ ажилдаа ирж Та бүхэн идэвх, сэтгэгдэлтэй оролцох вэ?

Ирэх жил ипотекийн зээлийн санхүүжилтийн дүнг харж байгаад бид ипотекийн зээлийн цоо шинэ бодлого гаргахгүй бол арилжааны банкууд зөвхөн өөрийнхөө санхүүжүүлж байгаа барилгаас зээл ав гэж шахдаг. Авсан нөхцөлд зээлээ өг гэж шахдаг. Эсвэл янз бүрийн очер дугаар урагшлуулахын тулд мөнгө төгрөг авдаг гэсэн олон гомдлууд ирж байна.

Энэ дээр Сангийн яам ямар байр суурьтай байгаа вэ?

Энэ дөрвийг хариулаад өгнө үү. Сүүлд нь нэг асуулт байна.

Сая хүн болгон ярьж байгаа даа. Манай багш нарын асуудлыг ярьж байгаа. Би боловсролын салбарт их ойр ажилладаг хүн байгаа юм. Энэ жил цалин нэмэх боломж байна уу, байхгүй юу? Тэрийгээ үнэнээр нь хариулж өгөөрэй.

Хэдэн багш нараа бид чинь Солонгос руу алдаад дууслаа шүү дээ. Бүгдээрээ Солонгос руу явдаг. Гурав гурван сараар. Тэгээд хамгийн сайн багш нар хаана байдаг вэ гэвэл “тогтвортой багш” нар л байгаа юм. Тогтвортой ажилладаг багш нар л байгаа юм.

Тийм учраас багш нарынхаа цалинг, эмч нарынхаа цалинг би нэмэх саналтай 100 хувь санал нэг байгаа. Энэ дээр ер нь ямар шийдэл гарсан бэ? Энэ дөрвийг асууя.

Х.Ганхуяг: Хэн хариулах юм? 6 номер.

Ж.Дэлгэржаргал: Гишүүний асуултад хариулъя. Сангийн яам. Ж.Дэлгэржаргал.

Солонгосын ЭКСИМ банкны нэн хөнгөлөлттэй зээлээр Хан-Уул дүүргийн Яармагт 5 мянган айлын “Солонго-1, 2” төсөл хэрэгжиж байгаа.

Одоогоор нийт гүйцэтгэл 50.0 хувьтай, зээлээ ашиглалт 43.0 хувьтай. Ирэх жил гадаад зээлийн ашиглалтыг нийтдээ 1.5 их наядыг төлөвлөсөн. Энэ дотор яг “Солонго 1, 2”-той холбоотой ашиглалтын хэмжээг 70.0 тэрбумаар тусгасан байгаа.

Хан-Уул дүүрэгт хэрэгжих сургууль, цэцэрлэгийн хувьд 2028 он хүртэлх хоёр ээлжээс дээш коэффициенттой байршил дээр Хан-Уул дээр 15 сургууль хэрэгтэй гэж гарсан. Их өгөгдлөөрөө. Энэ 15 сургуулиас яг улсын төсөв талдаа бэлэн бие даасан зураг төсөвтэй сургууль, цэцэрлэг шаардлага хангаж ирээгүй учраас улсын төсөв дээр шинэ сургууль, цэцэрлэг байхгүй байгаа.

Харин Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлд Хан-Уул дүүрэгт орсон байна. Улсын төсөв дээр одоо яг хэрэгжээд явж байгаа 1 сургууль, 1 цэцэрлэг Хан-Уулд 2026 онд ашиглалтад орохоор явж байна.

Х.Ганхуяг: Тэр багш нарын цалинтай холбоотой асуудлыг хэн хариулах юм. Ипотекийн зээл. 6 номер.

С.Тулга: Сангийн яам. С.Тулга. Гишүүний асуултад хариулъя.

Иирэх онд хуримтлалын санд ногдол ашгийн орлогоор 372.9 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын орлогоор 156.0 тэрбум төгрөг. Нийт 528.9 тэрбум төгрөгийг ерөнхийдөө ипотекийн санхүүжилт гаргах боломжтой байна.

Х.Ганхуяг: Багш нарын цалин дээр хэн хариулах юм? Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: Ж.Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя.

Ипотекийн зээлийн асуудал Гэр бүл, нийгмийн хамгааллын яам руу шилжсэн байгаа шүү дээ.

Тэгэхээр таны ажлын хэсэгт тэр яамнаас л илүү их идэвхтэй оролцох ёстой.

Төсвийн харилцаанд энд шууд оролцоод байх зүйл энэ дээр маш бага. Баялгийн сангаас хуваарилалтыг нь сая тоог нь хэллээ. Түүнээс биш манай яамны шууд оролцдог асуудал биш шүү.

Х.Ганхуяг: Багш нарын цалин гээд асуугаад байна. Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Багш нарын цалин ганц гэлтгүй төрийн албан хаагч нарынхаа цалинг нэмэх төсвийн хязгаар, боломж ямар байгааг Та бүхэн танилцуулаад явж байгаа төсвөөс харж байгаа байх.

Тэгэхээр одоо нэгэнт Улсын Их Хурал дээр өргөн барьсан байгаа учраас нөгөө яриад байгаа 200 хуулиар яаж яаж төсөв нэмж хуваарилсан байдаг вэ. Үүнийгээ бүгдээрээ нэг эргэж харцгаая. Бид жагсаалтаа хүргүүлсэн байгаа. Улсын Их Хурал дээр.

Тийм учраас одоо тийм бодлогын орон зай байхгүй хүнд үед бид тэр олон хуулиудыг эрэмбэлэх зайлшгүй шаардлагатай. Тийм. Тэгж байж л эндээс орон зай гарна. Түүнээс одоо Засгийн газар шууд энэ дээр оролдоод байх боломж хязгаар маш бага шүү дээ.

Тэгээд дээрээс нь 5 дахь өдөр төсвийн 2 дугаар хэлэлцүүлэг болно. Хэрвээ энэ дээр янз бүрийн попроод алдагдалгүй төсөв гээд буцаах юм бол 1.3 их наядаар хөрөнгө оруулалт маань буураад, бүр төсвийн бодлогын ямар ч орон зай үлдэхгүй маш хүнд байдалд орохоор байгаа. Тийм.

Х.Ганхуяг: Ж.Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: “Солонго-1, 2” хорооллын хувьд Б.Жавхлан сайд бүр анхааралдаа авмаар байгаа юм. Энэ бол ерөөсөө яг гамшиг болж байгаа. Би зориуд асуугаад байдаг нь энэ ерөөсөө ямар ч сургуульгүй баригдаж байгаа.

Тийм учраас би энэ удаагийн төсвийн ажлын хэсэгт өөрөө ороод ирэх он санхүүжих дүн дээр нь хаалт тавина шүү. Энэ барилга ашиглалтад орох юм бол 5 мянган хүүхэд огт сургуульгүй газар орох нь.

Тийм учраас миний хувьд тэр 70.0 тэрбум төгрөгөөр энэ оны санхүүжилтийг нь түр зогсоогоод эхлээд сургууль, цэцэрлэгээ барих шаардлага тавимаар байгаа юм. Ямар ч сургууль, цэцэрлэг байхгүй. Тэнд. Та нар очоод үзээрэй.

Тэгээд ер нь улсын төсвөөс орон сууц санхүүжүүлж болдог ч юм уу, үгүй ч юм уу. Ямар учиртай ч байдаг юм.

Хоёрдугаарт нь, тэр ипотекийн зээлийн асуудалд одоо тэр Зээлийн батлан даалтын сан Сангийн яамных байлгүй дээ. Үгүй юм болов уу? Тэр энэ тэрийгээ бас оролцуулж өгөөч ээ гэж байгаа юм.

1 минутаа нэмээд авъя. Тэгэх үү? 1 минутаа нэмээд авъя.

Х.Ганхуяг: Нэмээд ав. Минутаа. Ж.Алдаржавхлан гишүүний микрофоныг өгье.

Ж.Алдаржавхлан: Тэгээд манай сонгогчид харж байгаа. Би 7 сард энэ саналаа өгсөн. Сангийн яаманд.

Тэгээд сургууль, цэцэрлэг тавигдсангүй. Энэ дээр их харамсалтай байна. Бид боломжийн байршлууд дээр, ялангуяа Хан-Уул дүүргийн тэр Яармаг хавьцаа улсын сургууль байхгүй болоод удаж байгаа шүү дээ.

Тэгээд саналуудаа өгсөн. Үүнийг тэр Азийн хөгжлийн банкны гэж ярьж байгаа. Тэр нь яг хэзээ яаж хэрэгжих юм байгаа юм? Саналуудаа өгсөн. Нэг ч сургууль, цэцэрлэг тусаагүй байна.

Хэрвээ хөрөнгийн боломж гараад Б.Жавхлан сайд аа, бас нэмж оруулах бололцоо байгаа юу, үгүй юу? Үүнийг нэг хариулаад өгөөч ээ гэж.

Х.Ганхуяг: Асуулт асуув уу? Та үг хэлсэн үү? Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье.

Зээлийн батлан даалтын сан “Солонго-1, 2”-ын хувьд одоо хэдүүлээ энд ингэж айхтар хүчлээд хэрэггүй байгаа юм даа. Тэрний оронд та энэ Боловсролын яамтайгаа ажиллах хэрэгтэй. Боловсролын яамныхаа тэр “Их өгөгдөл” дотор тэр нөхцөл байдлыг нь газар зүйн байрлалаар нь оруулах хэрэгтэй.

Тэгээд тэр эрэмбэ судалгаагаар гарч ирэх хэрэгтэй. Тэгж байж энэ ном журмынхаа дагуу явна. Түүнээс биш зураг төсөв байхгүй, бэлэн байдал хангаагүй нөхцөл байдалд сургууль тавина гэж би лав попорч чадахгүй. Тийм. Наадах чинь хэтэрхий попролт болно. Гишүүн ээ. Тийм.

Тэгэхээр манай хууль тогтоох байгууллага Улсын Их Хурал төсөв батална. Бид хуулиа бид хамгийн үлгэр жишээ барьж байх ёстой. Төсвийн шаардлагуудыг үлгэр жишээ барих ёстой.

Тэгэхээр хугацаа хэрэгтэй юм байна. Сургууль, цэцэрлэг дээрээ магадланг нь гаргах хэрэгтэй. Гарцаагүй бэлэн байдалд орсон төсвийг төсвийн хэлэлцүүлгийн үеэр нэмэх хасах саналууд л явна уу гэхээс одоо тэнд бэлэн байдал хангаагүй төсвүүд яригдах учиргүй. Улсын Их Хурал өөрөө ийм төсөл батлах учиргүй л байгаа юм.

Барилгын яамнаас явах учиргүй л дээ. Сургууль, цэцэрлэг Боловсролын яамнаас л явна. Барилгын яамнаас явахгүй.

Х.Ганхуяг: Ж.Баясгалан гишүүн.

Ж.Баясгалан: Х.Ганхуяг дарга аа, төсөв ярьж байхад ганцхан сайд сууж байна. Сангийн сайд. Тийм. Тэгээд ер нь уг нь бусад сайд нар маань байгаасай. Байх ёстой шүү дээ. Асуух тодруулах юм байна. Сая гэхэд л хавдрын эмнэлгийн талаар асуухад тэгээд буруутан нь байхгүй байгаад байна шүү дээ. Энд. Сангийн яам бид ингэж ажилласан гээд л ярьж байна.

Тэгэхээр уг нь сайд нар байж байгаад энэ дээрээ асуувал тодорхой болох гээд байна. Тэгэхгүй бол асуух болгонд Сангийн сайд л байдаг. Нөгөө Жавхлан, Баясгалан гэдэг шиг бид хоёр нэг асуултыг дахин дахин л асууж байна. Нээрээ шүү. Одоо бараг цээжилсэн.

Тэгэхээр энэ бол асуулт биш. Би нэг шаардлага хэлэх гээд байгаа юм.

■ **Монгол Улсад 112 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг.**

Үүнийг Их Хуралд сууж байгаа бүх гишүүд цээжилсэн. Орж ирж байгаа ажлын хэсгийнхэн бүгдээрээ цээжилсэн.

Энэ чинь өрх гэсэн үг шүү. Нийт өрхийн 13 хувь нь шаардлага хүргүүлж байгаа. Тэр нь юу вэ гэвэл өнөөдөр Монгол Улсад хэрэгжиж байгаа:

- Амьжиргааны доод түвшин Улаанбаатар хотод 495 мянган төгрөгөөр 2025 онд тогтоогдсон байгаа.
- Тэтгэврийн доод хэмжээ 689 мянга.
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 792 мянган төгрөг.

- Тэгэхэд нийгмийн халамжийн тэтгэвэр өнөөдөр 397 мянга 500 төгрөг.
- Нийгмийн халамжийн асаргааны буюу тэр хүүхдээ асарч байгаа ээж, нөхрөө асарч байгаа эмэгтэй, ээжийгээ асарч байгаа тэр хүнд очиж байгаа мөнгө болохоор 302 мянга 500 төгрөг.

Энэ чинь хөдөлмөр эрхэлж байгаа хүн шүү дээ. Хүн асарч байгаа бол 24 цагийн турш хамгийн хүнд хөдөлмөрийг эрхэлж байдаг.

Үүнийг одоо хэл ам хийсээр байж арай нэмэгдсэн нь Байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа эцэг, эхүүд 445 мянган төгрөг авдаг болсон.

Үүний аль нь ч тэтгэврийн доод хэмжээ, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээндээ дөхөхгүй байна. Үндсэн хуулиар амьд явах эрх нь хэрэгжихэд хэцүү байна.

Та нар бодоод үз дээ. Өнөөдөр яг 302 мянган төгрөг аваад өвчтэй хүнээ асраад, хүүхдүүдээ сургуульд явуулаад, хоолоо идээд, цахилгаанаа төлөөд, нүүрсээ түлээд ингээд амьдрах боломжтой юу. Энд байгаа хүмүүс 397 мянган төгрөгөөр нэг сар амьдрах гээд үз дээ. Дээр нь өвчтэй шүү.

Тэгэхээр энэ хэсэг яагаад яригдахгүй байна вэ гэвэл энэ хэсэг маань өөрсдөө гудамжинд гарч жагсдаггүй. Гэртээ өвчтэй байгаа учраас. Бид багш нарын тухай, ахмадуудын тухай ярьж байна. Зөв. Гэхдээ ор тас яригдахгүй байгаа энэ хэсэг маань бүр нийгмээс тусдаа нэг анги давхарга болоод байна шүү дээ.

Одоо үүнийг бүгдээрээ тодорхой хуваарь байна шүү дээ. 1 минутаа нэмээд авъя. Дарга аа. Тодорхой хуваарь биш, үүнийг хэдүүлээ ядаж... /минут дуусав/

Х.Ганхуяг: Минутыг нь нэмээд өгөөрэй.

Ж.Баясгалан: Монгол Улс мэдээж **“Халамжаас хөдөлмөрт”** гэсэн уриатай

Тэгэхээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага байх ёстой.

Тэгвэл бид үүнийг нэг нэмье л дээ. Бүгдийг нь нэмье. 66.0 хувь нэмж байж бид ойролцоогоор тэр мөнгөнүүд нь ерөөсөө 600 мянган төгрөг л болж байна. Ингэж байж энэ хүмүүс маань ядаж амьд явах эрх нь хангагдана. Ядаж амьд байх. Сайхан амьдрах эрх байхгүй тэр хүмүүст. Амьд байх эрх нь хангагдана.

Энд хэдэн төгрөг шаардлагатай юм бэ? Энд 400 тэрбум төгрөг шаардлагатай. Халамж гээд ярихаар бид маш ихээр бодоод байдаг. Гэтэл хөгжлийн бэрхшээлтэй энэ 113 мянган хүмүүсийн халамжид бид нэмэхэд бусад

хүмүүсийн хөдөлмөрийн хөлсний хэмжээ биш ээ. Тэтгэврийн доод хэмжээнээс бага болгоход л бид нарт 400 тэрбум төгрөг шаардлагатай байгаа.

Х.Ганхуяг: Эхлээд Ж.Баясгалан гишүүн ээ.

Дэгийн тухай хуулиар төсвийн хоёр дахь хэлэлцүүлэг дээр 70.2-оор Байнгын хорооны хуралдаанд гишүүд тухайн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч буюу Сангийн яам. Манай Байнгын хорооны.

Сангийн яам, Монгол Улсын ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга болон бусдаас асуулт асууж, үг хэлнэ гэсэн байгаа. Тийм болохоор өнөөдөр Сангийн яам болон бусад нь байна гэсэн үг.

Тэгээд гишүүний асуултад хэн хариулах вэ? Тийм. Үүнийг яах вэ, та чуулган дээр энэ төсвийг хэлэлцэж байхад асуулт асууж болох байх гэж бодож байна. Тийм. Яг тэр чиглэлийн хүн нь байхгүй байгаа болохоор хариулах боломжгүй юм байна.

Өөр тодруулах уу? Ж.Баясгалан гишүүний микрофоныг өгье.

Ж.Баясгалан: Тийм. Үгүй яг үнэхээр үнэн л дээ. Асуух болгонд л Б.Жавхлан сайд сууж байдаг. Тэгээд дандаа л асууж, дандаа л нэхэж байдаг.

Тэгэхээр энэ дээр манай бүлэг дээр ажлын хэсэг гарсан. Төсөвтэй холбоотой. Тэгээд Б.Түвшин гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг үзээд 2.3 их наядыг танаж, асаргааны тэтгэмж, нийгмийн халамжийн тэтгэвэрт шаардагдах мөнгийг гаргах боломжтой гэж ажлын хэсэг үзсэн байгаа. Тийм болохоор үүнийг ярьж байгаа юм шүү.

Тэгээд энэ салбарын сайдтай чуулган дээр яг энэ асуудлыг бүр тодорхой сайн ярилцъя. Гишүүд маань ч гэсэн ойлголттой болоод ав. Тэгэхгүй бол гудамжинд гарч жагсаж, уйлж дуулж чадахгүй байгаа учраас үүнийг мэдэхгүй өнгөрөөд байгаа.

Гэтэл яг үнэндээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрал өнөөдөр яг энэ түвшинд байгаа шүү.

Х.Ганхуяг: Энэ дээр Б.Жавхлан сайд нэг тайлбар өгмөөр байна. Энэ 2.3 их наядаар хурал цуглаан хийх гээд байна гээд яриад яваад байх юм. Тийм юм байгаа юм уу?

Б.Жавхлан сайдын микрофон өгье.

Б.Жавхлан: Ингэсэн байгаа. Ноднин Их Хурал дээр төсөв хэлэлцэж байх үед нэг асуудал нэлээн хөндөгдөж байсан. Бусдаар гүйцэтгүүлэх зардал буюу хувийн хэвшилд мөнгө төлж ажил, үйлчилгээгээ хийлгүүлж байгаа. Өөрөөр

хэлбэл төр зарим төрлийн ажил, үйлчилгээгээ хувийн хэвшлээр хийлгүүлж байгаа ийм л зардлууд шүү дээ.

Тэрийг одоо эдийн засгийн ангиллынх нь нэрэнд нь нэлээн аллергидсан байх. Тэгээд үүнийгээ задалж оруулж ир гэсэн байгаа.

Тэгэхээр өөр нэлээн хэд хэдэн эдийн засгийн ангиллын шинэ зардлууд руу шингэж орж ирсэн байгаа. Хэмнэгдэх нь хэмнээд, тавигдах нь шинээр тавигдаад.

Тэр дотор тийм зардлууд орсон байгаа. Тэгэхдээ 2.3 их наяд гэдэг бөөн дүнтэй тийм зардал байхгүй, хаана ч байхгүй. Үүнийг Б.Түвшин гишүүнээс яг өөрөөс нь харин сонсмоор байна. Хэвлэлд тярилцлага өгсөн байна лээ. Тийм бол ажлын хэсэг дээрээ ярилцаад явах нь зөв байх. Тийм.

Х.Ганхуяг: Ч.Номин гишүүн асуулт асууя.

Ч.Номин: Би хоёр асуулт байна. Нэг нь хөрөнгө оруулалттай холбоотой.

Хөрөнгө оруулалт дээр нийтдээ 579 хөрөнгө оруулалтын төслүүд байна. Үүн дотроос 66 нь тоног төхөөрөмж. Үүн дотроосоо 63 нь шинэ тоног төхөөрөмжүүд байна. Багцлаад орж ирсэн.

Энэ нь нийт төсвийн 17 хувийг эзэлж байна гээд аудитын дүгнэлтээр гараад ирсэн.

Би энэ шинээр орж ирж байгаа 63 тоног төхөөрөмжийн багц дээр яг хэдэн хувь нь боловсрол, хэдэн хувь нь эрүүл мэндэд зориулж байгаа вэ гэж асуумаар байна. Яагаад вэ гэхээр тоног төхөөрөмжийн хувьд энэ удаад маш өндөр өртөгтэй болж орж ирсэн. Түрүүн Х.Булгантуяа гишүүн хэлж байна лээ. 1 орчим их наяд болж орж ирсэн гээд. Тэгээд одоо бид сая асуудлууд хөндөгдсөн. Тийм ээ. Хүүхдүүд бүрэн хэмжээний тоног төхөөрөмжгүйгээсээ болоод сургуульдаа гурваараа ширээн дээрээ сууж байна гэх мэтчилэн.

Тэгэхээр тоног төхөөрөмжөөс хэдэн хувь нь боловсролын салбар зарцуулагдахаар багцаараа хэдэн төгрөгийн өртөгтэйгөөр орж ирж байгаа вэ гэж асуумаар байна.

Хоёр дахь асуулт болохоор төсвийн орлого бүрдүүлэлт дээр асуулт байна. Би үүнийг Их Хурал дээр асуусан. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого бүрдүүлэлт дээр 706.0 тэрбум төгрөгөөр орлого бүрдүүлэлтээ нэмэгдүүлнэ гэж орж ирсэн.

Би Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас асуугаад хариултаа авсан. Энэ хариулт нь ч хангалттай биш байгаа учраас би асууж байна. Яаж энэ орлого бүрдүүлэлтээ нэмэгдүүлж байгаа юм бэ? Та бүхний өгсөн тайлбар бол 28

мянган хүний тоо өсөөд, цалингийн дундаж 6.3 хувиар өсөөд ч энэ хэлээд байгаа дүн гарч ирэхгүй байна. Би одоо яг ямар байдлаар үүнийг гаргаж ирж байгаа вэ гэдэг асуулт байна.

Дахиад нэг асуулт. Цаг байгаа учраас асууя. Энэ аудитын дүгнэлт дээр гарсан дүгнэлтийн хамгийн хойд тал дээр байгаа нэгдсэн дүгнэлтийн 10 дээр байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн орлогын 10 хүртэлх хувьтай тэнцүү хэмжээгээр байгуулна гэсэн заалтыг мөрдөөгүй байна. Энэ нь эрсдэлийн үед хүнд нөхцөл байдалд хэрвээ бид дахиад томоохон хэмжээний ковид шиг зүйлүүд гарч ирвэл эрсдэлтэй үед бид эрсдэлийн сангаа бүрдүүлээгүй байна гэдэг дүгнэлт гарч ирсэн байна. Би үүнийг өмнө нь асуугаад хариултаа авч чадаагүй учраас дахиад асууя. Ингээд гурван асуултад хариулт өгөөч ээ.

Х.Ганхуяг: Хэн хариулах юм. 6 номер.

Ж.Дэлгэржаргал: Ч.Номин гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Ж.Дэлгэржаргал.

Төсвийн төслийн 2 дугаар хавсралтад Улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр нийтдээ 3.2 их наядын 482.0 тэрбум нь тоног төхөөрөмжийн төслүүд байгаа.

Энэ дотор 5 салбар дээр хамгийн өндөр буюу

- Байгаль орчны салбар 91.0 тэрбум. СОР-ын хурал болон радарын станцтай холбоотой. Нийт тоног төхөөрөмжийн 19 хувь.
- Боловсрол 56.6 тэрбум. Нийт тоног төхөөрөмжийн 12 хувь.
- Эрүүл мэнд 49.7 тэрбум. Нийт тоног төхөөрөмжийн 10 хувь.
- Хууль, батлан хамгаалах, онцгой, цахимжилт дээр дараагийн салбарууд байгаа.
- Соёлын салбар нийт тоног төхөөрөмжийн 2 хувь буюу 9 тэрбум байгаа.

Х.Ганхуяг: Хариулт хангалттай юу? Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж мэдээлэл өгье.

Энэ жилийн тэр 482.0 тэрбум төгрөг шүү. Тэр яагаад хаанаас юун 1 их наяд гээд гараад ирэв ээ. Энэ чинь олон нийтэд дэлгээд тавьсан байгаа төсөв дээрээс ганцхан л тоо шүү дээ. 482.0 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж бүгд нийлээд шүү.

Энэ дотроос хамгийн том тэр СОР байна. 91.0 тэрбум гээд.

Энэ бол тэгэхдээ дамжиж хөрөнгө оруулалтууд хийгдэнэ. 91-ээрээ бас гүйцэхгүй байгаа юм. Ийм зүйлүүд байна.

Дээрээс нь энэ тоног төхөөрөмжийн худалдан авалттай холбоотой нэг зүйл хэлэхэд төсөв дээрээ тавьж байгаа сайд нар маань одоо 6 сарын 01-н гэдэг хугацаандаа худалдан авалтаа амжилттай хийх хэрэгтэй. Бөөн юм болж төсөвт тавьдаг. Тухайн жилдээ хийхгүй хураалгахаар. Маш хариуцлагагүй салбараас.

Тэгээд энэ чинь яг тэр ачааллаараа хойтон жил дээр дамжаад очиж байгаа юм. Энэ жил эрүүл мэндийн салбар дээр маш харамсалтай зүйл болсон. 50 гаруй тэрбум төгрөг тавьсан байсан. Гэвч худалдан авалтаа хийж чадаагүй. Соёлын салбар дээр ч тэр. Боловсролын... /минут дуусав/

Х.Ганхуяг: Гурав дахь нь юу юм? Аан. Нийгмийн даатгалын орлоготой холбоотой асуулт асуусан юм байна. Тэрийг хэн хариулах юм? М.Санжаадорж хариулах уу? М.Санжаадорж 2 номер.

М.Санжаадорж: Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийг Улсын Их Хурал дээр нийт дүнгээр нь баталдаг.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл Улсын Их Хурлаас байгуулагдсан Үндэсний зөвлөл дээр нарийвчилсан хувиар нь баталдаг. Тэнд эрсдэлийн сангийн 10 хувийг батлах учиртай. Гэхдээ яг бодитоор одоо Эрүүл мэндийн даатгал дээр эрсдэлийн сан байгуулж авч үлдэх байтугай энэ жилийн гүйцэтгэлээ өгөхөд хүндрэлтэй болоод байгаа ийм асуудал байгаа.

Тэгэхээр эрсдэлийн сан байгуулахгүйгээр энэ бүх зардлаа гүйцэтгэлдээ өгөхөөр ийм тооцоолол байгаа юм.

Нийгмийн даатгалын сангийн орлогын хувьд татвараас авч байгаа хувь хүний орлогын албан татвар тооцож байгаа улсын нийт цалингийн сан болон нийгмийн даатгалын шимтгэл тооцож авч байгаа улсын цалингийн сангийн энэ хоёр дээр тооцоолоод нийлүүлж мөргүүлж бид тооцоолж байдаг.

Ирэх жилийн хувьд 23 их наяд төгрөгийн улсын нийт цалингийн сан байна гэдгээр бид тооцож байгаа. Энэ хүрээндээ... /минут дуусав/

Х.Ганхуяг: Ч.Номин гишүүн.

Ч.Номин: Би нийгмийн даатгалын сантай холбоотой асуудлыг болохоор би ер нь яагаад үүнийг дахин дахин давтаж хэлээд байгаа вэ гэхээр төсвийн

хүрээний мэдэгдэл, бодлогыг ярьж байхад ч гэсэн манай орлого бүрдэхгүй байх магадлал өндөртэй байна гээд олон улсын зах зээл дээр нүүрсний үнэ унаж байгаа. Дахиад бид нүүрснийхээ бодит хэмжээг нэмэгдүүлж чадахгүй гэж үзэж байгаа учраас буруу орлого бүрдүүлэлт тооцоолох гээд байна гэж эрсдэл үүсэх вий гэж бодоод.

Нийгмийн даатгалын сан дээр бодит 440.0 тэрбум төгрөгийн зөрүүтэй орлого бүрдүүлнэ гээд бичээд байгаа юм. Тэгээд нийгмийн даатгалын сангийн энэ холбогдолтой зүйлийг Т.Аубакир сайд яг бодитой тайлбар хэлмээр байгаа юм. Яагаад вэ гэхээр энэ дүн ерөөсөө яагаад ч ийм хэмжээнд болохооргүй тооцоолол байхад тооцооллоо гаргаж ирэхдээ зөрүүтэй тооцоолол гаргаж ирж бичээд орлого дээр тавиад байгаа. Үүнийг л тайлбарлаад өгөөч гэж байна.

Тэгэхээр би одоо Т.Аубакир сайдаас асуулга дахиад авъя гэж бодож байна.

Х.Ганхуяг: 2 номер.

М.Санжаадорж: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөгөө манайд ирүүлсэн байгаа. Энэ орлогын төлөвлөгөө Сангийн яаманд хянагдахдаа зөвхөн нэг орлогыг нь л бид өөрчилж тавьсан.

Энэ нь чөлөөт үлдэгдлээс хүү олох асуудал байгаа. Энэ нь энэ жилд 26 тэрбум төгрөг байна уу даа. Гүйцэтгэл дээр тийм юм явж байгаа. Биш ээ. Төлөвлөгөө байсан боловч гүйцэтгэл дээр 130 хэдэн тэрбум төгрөг орлоо. Энэ хэмжээгээр л нэмэгдүүлсэн.

Түүнээс биш Хөдөлмөрийн яамтай бид ямар нэгэн байдлаар энэ тоон дээр зөрчил үүсээгүй. Яг тэдний ирүүлсэн тоо манай татвараас ирж байгаа нийт цалингийн сангийн тоотой мөргөж байгаа.

Тэгэхээр хоёр яамны хувьд зөрчил байхгүйгээр яг тооцоолол таарсан байгаа шүү.

Х.Ганхуяг: Д.Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Надад хэд хэдэн асуулт байна.

Нэгдүгээрт, Цахим, харилцаа холбооны яам байгаа билүү? Сангийн яам, Э.Батшугар сайдын яамнаас л асуумаар байна.

Шүүхийн шийдвэрийн өр 2.4 тэрбум төгрөгийг төлнө гэж Цахим, харилцаа холбооны яамнаас саналаа ирүүлсэн. Сангийн яам 1.2 тэрбумаар нэмсэн юм байна. Энэ яагаад нэмсэн юм бэ? Ирсэн саналаас нэмэгдүүлж хянасан байна л даа.

Хоёр дахь асуулт. Сангийн яам, Дэлхийн банк болон Япон Улсын санхүүжилтээр Багануур, Шивээ-Овоо компаниудад 1997 онд дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөгдөхгүй байгаа өр төлбөрт 167.2 тэрбум төгрөгийг улсын төсвөөс төлөхөөр тооцжээ.

Энэ яагаад тэр хувьцаат компаниудын өрийг төсөвт тусгаж байгаа юм бэ? Энэ хууль тогтоомжтой нийцэж байгаа юм уу?

Гуравдугаарт нь, би энэ навигацийн орлогыг тодруулах гэсэн юм. 2022-2024 онд 3 жилийн дүнгээр аваад үзэхэд навигацийн орлогыг 844.2 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байгаа юм. Гүйцэтгэл үүнээс бага гарсан. Гүйцэтгэл яах вэ.

Гэтэл энэ төлөвлөсөн дүнгээсээ улсын төсөвт төлөвлөж байгаа дүнг нь 300.0 тэрбум. Өөрөөр хэлбэл навигацийн орлогыг улсын төсөв дээр бүтэн тусгадаггүй. Тэгсэн хэрнээ Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа нэг аж ахуйн тооцоот газар дээр яваад байдаг. Энэ төсвөөс гардуур ийм орлого, зарлага байж болдог юм уу?

Зам, тээврийн яам, Сангийн яам хоёр сайд хамтраад энэ төсвийн зардлыг батлаад байгаа юм. Үүнийг тодруулж өгөөч.

Инфляцын талаар би тодорхой тоотой болмоор байна. Түрүүн Эдийн засгийн байнгын хороо хуралдаж байх явцад Монголбанкны Ерөнхийлөгчөөс би инфляцын энэ оны гүйцэтгэлийг асуусан. 8 хувь гэж байна лээ.

Ж.Ганбат дарга төсвийн хэлэлцүүлгийн үеэр. Бид төсвийн хэлэлцүүлгийг 5, 6 салбараар хийсэн. Энэ үеийн танилцуулга дээр 9.5 гэж хэлсэн. Яг хэд юм бэ? Энэ дүнгээ бодитой болгоод өгөөч.

Засгийн газрын нөөц сан яг одоо Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас анхны ирсэн санал хэдээр ирсэн юм бэ? Үүнийг тодорхой болгож болох уу?

Бид саяхан аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулаад нийгмийн хариуцлагын хүрээнд элэгдэлд тооцох үндсэн хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх буюу нийгмийн чиглэлээр хандив, тусламж үзүүлэх юм бол энэ зардлыг нь татвараас нь суутган тооцох, нийт татварын хөнгөлөлт нь нэг хувиас хэтрэхгүй байхаар нэг хуулийн зохицуулалт оруулсан.

Төрийн өмчит компаниудын энэ нэг хувь хэрхэн яаж төлөвлөгдөж, хаана яваад байна? Үүнийг хэн захиран зарцуулах талаар журамласан зүйл байна уу? Өөрөөр хэлбэл татварын орлогод орох ёстой байсан төсвийн орлогыг дахин хуваарилалт хийж зарцуулж байгаа асуудал. Үүнийг хэн... /минут дуусав/

Х.Ганхуяг: Хэн хариулах юм? 2 номер.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж.

Гишүүний асуултад хариулъя. Зарлагатай холбоотой хэсгүүд дээр нь.

Энэ жилийн хувьд нийтдээ 58 төсвийн ерөнхийлөн захирч байгаа.

- ▶ Орон нутгийн 22.
- ▶ Улсын төсөв дээр бол үлдсэн нь.

Энэ дундаа 17 нь Улсын Их Хурал шууд хариуцан тайлагнадаг байгууллагууд. Үлдсэн нь Засгийн газрын харьяа байгууллагууд байгаа.

Энэ дундаас Цахим хөгжил, харилцаа холбооны яам ганцаараа төсвийн хязгаартаа багтааж саналаа ирүүлсэн. Тэгээд төсвөө хянуулж байх явцдаа энэ хязгаартаа багтсан байдлаар төсвийн саналаа өөрчилж хянагдсан асуудал байгаа.

Хоёр дахь нь, навигацийн орлогыг зарцуулах асуудлыг Зам, тээврийн сайд, Сангийн сайд хоёр хамтарсан тушаалаар зарцуулж байгаа зүйл байхгүй.

Улсын Их Хурал дээр бид навигациас төвлөрүүлэх орлогын хэмжээг тавьж байгаа. Үлдэж байгаа навигацийн орлогын хэмжээг Зам, тээврийн сайд бие даан зарцуулах шийдвэр гаргаж байгаа.

Засгийн газрын нөөц сангийн хувьд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас санал ирдэггүй. Энэ бол Сангийн сайдын багцад байдаг. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиараа.

Тэгээд энэ дээр харин зөвлөмжүүд ирдэг. Улсын онцгой комиссоос энэ жилийн хувьд өвөлжилтийн бэлтгэл байдал ямар байна, ер нь ямар байдалтай ирэх жилдээ байгалийн гамшигтай холбоотойгоор байна гэдэг асуудлаар зөвлөмжүүд ирдэг. Энэ зөвлөмж дээр аймаг, нийслэлийн Засаг даргын нөөц сан болон Засгийн газрын нөөц санг нэмэгдүүлэх шаардлагатай гэдэг чиглэл ирсэн.

Яг хууль дээр юу гэж заасан байдаг вэ гэхээр дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хүртэл хувийн хэмжээтэйгээр нөөц санг байгуулж болно гэсэн заалттай байдаг. Баярлалаа.

Х.Ганхуяг: Асуулт бүрэн үү? Хариулт бүрэн үү? Д.Үүрийнтуяа гишүүн ээ? Болоогүй байна уу? С.Тулга. 2 номерын микрофон өгье.

С.Тулга: Багануур, Шивээ-Овоогийн дамжуулан зээлтэй холбоотой асуултад хариулъя.

С.Тулга. Сангийн яам.

167.0 тэрбум төгрөг маань үндсэн төлбөр, хүүгийн төлбөр болон Багануур Шивээ-Овоо компаниуд дээр хуримтлагдсан байгаа хугацаа хэтэрсэн эргэн төлөлт бүгд нийлээд 167.0 тэрбум төгрөг болж байгаа.

Үүнийг улсын төсвөөс гаргахгүй. Энэ хоёр байгууллага маань өөрөө “Эрдэнэс Монгол”-ын групп компанийн нэгдэлд орж байгаа учраас нэгдлийнх нь гишүүн компани болох энэ хоёр компанийн хугацаа хэтэрсэн зээлийг ерөнхийдөө төлж барагдуулах энэ асуудлыг “Эрдэнэс Монгол” хариуцаад явахаар байгаа.

Х.Ганхуяг: Өөр ямар асуулт байгаа билээ? Инфляцтай холбоотой асуултыг хэн хариулах юм? Татвар. И.Батхүү 3 номер.

И.Батхүү: Д.Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя.

Инфляцын яг одоо 8 сарын байдлаар 8.8 хувийн гүйцэтгэлтэй.

Үндэсний статистикийн хорооны гаргасан тоогоор 8.8 хувьтай байна.

Монголбанкны хувьд 4-өөс 8 хувийн хооронд интервалаар зорилтоо тавьж явж байгаа. Энэ оны эцсээр сая танилцуулагдсан мэдээллээс харахад 8.1 хувьтай гэсэн тоо гаргасан байна лээ.

Эдийн засаг, хөгжлийн яамны хувьд оны эцсээр 8.6 хувьтай инфляцын хүлээгдэж буй гүйцэтгэл гарах байх гэсэн тооцоололтой байгаа.

2026 оны хувьд 7 хувийн инфляцын зорилт тавьж байгаа. Сая танд танилцууллаа. 8.6 хувь гээд.

Х.Ганхуяг: 2 номер. Татвар. Тийм.

Ч.Чимидсүрэн: Д.Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 22.9-тэй холбоотой 2024 онд нийт 87 төслийн 44.5 тэрбумын хөнгөлөлт эдлэх тайлан мэдээллүүдийг ирүүлсэн байгаа.

2025 оны гүйцэтгэл он гарч тайлагнагдах учраас. Тухайлбал, тэр төрийн өмчит компани болон ер нь аль ч компаниудын хувьд ямар төсөл, хөтөлбөрүүд ирүүлж байгаа тэр мэдээлэл нь тухайн яамд дээрээ бодлогын хүрээнд хийгдэж байгаа байх.

Гүйцэтгэлээр одоогоор хагас жилийн тайлангаар тайлагнасан мэдээлэл байхгүй байна.

Х.Ганхуяг: Д.Үүрийнтуяа гишүүн тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Нэгдүгээрт, шүүхийн шийдвэрийн өр Цахим яамтай холбоотой асуудлыг би яг нийт хэдэн төгрөг төлөх байснаас, 2.4 төлөх байсныг 1.2-оор нэмсэн гэж байгаа юм.

Тэгвэл төсөвтөө багтаагаад хэдийг дахиад дутуу төлөхөөр байгаа юм? Өр нь дуусаагүй юм уу? Хэдэн төгрөгийн өрнөөс хувааж төлөөд байгаа юм? Нэг.

Хоёрдугаарт, Засгийн газрын нууц сангийн асуултыг маань ойлгосонгүй юу. Эсвэл Би буруу асуугаад байна уу?

Төсвийн ерөнхийлөн захирагчаас ирүүлсэн саналыг тодорхой тоогоор хэлээч ээ гэсэн байгаа. Үүнийг тодруулъя. Дахиад.

Гуравдугаарт, навигацийн орлогыг асуухдаа би буруу хэлэв үү, та буруу ойлгоод байна уу? Бас. Би зарцуулах тухай асуудал яриагүй юм л даа.

Сангийн сайд, Зам тээврийн сайд хоёр төсвийг баталж өгч байгаа. Баталж байгаа биз дээ. Навигацийн орлогын нийт орлого, түүнээс улсын төсөвт хэд өгөх юм? Хэдийг тэр нисэхийн үндэсний төв зарцуулах юм гэдгийг гаргаж байгаа байхгүй юу.

Х.Ганхуяг: Үг хэлсэн үү? Асуулт уу? Хэн хариулах юм? Навигацийн орлого. М.Санжаадорж 2 номер.

М.Санжаадорж: Сангийн яам. Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга. Гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт, навигацийн орлого дээр яадаг вэ гэхээр Улсын Их Хурлаас ирэх жилийн хувьд болон энэ жилийн хувьд 80 тэрбум төгрөгийг нь төсөвт татна гэж аваад, үлдэх хэсгээр нь Иргэний нисэхийн үндэсний төв гэж төрийн өмчит байгууллага байгаа. Энэ байгууллага дээр тэнд ажиллаж байгаа буюу 21 аймагт байгаа нисэх буудлуудын ажилчдын цалин хөлс болон навигацийн үйлчилгээнийх нь зардлыг санхүүжүүлэхэд зарцуулж байгаа.

Энэ шийдвэрийг хоёр сайдын хамтарсан тушаалаар гардаггүй. Энэ бол зөвхөн Зам, тээврийн сайдын тэр юугаар гардаг.

Цахим яамны шүүхийн шийдвэртэй холбоотой асуудал шүүхийн эцсийн шийдвэр гарсан. Тэгээд батлагдсан төсвийн хязгаартаа багтаагаад бусад зардлаа бууруулж байгаад оруулж ирсэн. Тухайн цахим яам бол. Тэгээд бүрэн туссан гэж бид ойлгож байгаа.

Х.Ганхуяг: Болсон уу? Танд 1 минут дахиад байж болно гэсэн үг. Д.Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Нэмээд нэг зүйлийг тодруулъя.

Төрийн өмчит компаниудаас авах ногдол ашгийн авлага 340.0 тэрбум төгрөг энэ оны төсөв дээр, орлого дээр орж ирээгүй байна. Ногдол ашиг дээр нэмж тооцоогүй байна.

Энэ яагаад орлого тооцохгүй байгаа юм бол? Боломжтой компаниуд. “Эрдэнэс Тавантолгой”, “Монголросцветмет”. Төлөх чадваргүй компани байхгүй байна лээ. Бараг 9 компанийн байв уу. Үүнийг тодруулъя. Хариулаад өгөөч. Нэмээд асуулт.

Х.Ганхуяг: Хэн хариулах юм? М.Санжаадорж.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя.

Ногдол ашгийг төвлөрүүлэх асуудал Төрийн өмчийн хороо орлого төвлөрүүлэгч байгууллагаар байгаа. Тэгээд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тооцож байгаа.

Ногдол ашгийг яаж тооцож байна вэ гэхээр тухайн байгууллагын ашгаас нь тооцож байгаа. Тэгээд бодит гүйцэтгэл дээр яг хуульд заасан тооноос бага зэргийн зөрүүтэй тоо гарч байгаа. Ер нь процесс нь яаж явдаг вэ гэхээр хуульд заасан тоогоо Төрийн өмчийн хороо өөрийнхөө харьяанд байгаа төрийн өмчит компаниуддаа бүгдэд нь хувааж өгдөг. Эдгээр компаниудаас бид нарт авч өгөх ёстой байдаг.

Х.Ганхуяг: Ж.Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Тэгэхээр Монгол Улсын 2026 оны төсвийнхөө материалуудыг нэлээдгүй судалж байна. Мэдээж Их Хурал би хэлэлцэхийг нь дэмжих байх гэж ингэж ойлгож байгаа.

Ер нь бид сүүлийн 2 жил дотор үндсэндээ бараг 5 их наядаар зарлагын өсөлтөө хязгаарлаж бууруулж чадлаа шүү дээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2025 оны төсөв дээр хориг тавьсантай холбогдуулаад бид 2.3 их наяд шиг санаад байна. Би зарлагаа бууруулцгаасан. Шинэ Засгийн газар байгуулагдаад 2.2 их наядаар билүү дээ, энэ чинь. Бууруулсан төсвөө тодотгол баталсан бид хэд.

Энэ жилийн орж ирсэн дахиад 520 орчим тэрбумаар зардлаа бууруулж орж ирж байгаа юм.

Ингээд тооцоод үзэх юм бол би 5 их наяд орчмоор хязгаарлалт хийж чадсан юм байна. Энэ нь үндсэндээ орлого дагасан хөөсрөлтөө ер нь бас энэ амаргүй нөхцөл байдалтайгаа уялдуулаад төсвийн эрүүлжилт гэдэг юм уу зөв төлөвлөлт, тэр орон зайн асуудал руугаа нэлээн тийм гайгүй чиг хандлага бий боллоо гэж ингэж харж байгаа.

Тэгээд мэдээж Засгийн газрын өргөн барьсан төсөв дээр ажиллаж нийт дүн хөдөлгөхгүйгээр зохицуулалтын ямар арга хэмжээнүүд байх юм гэдэг юмаа Их Хурал тал бүрээс нь авч үзэх болов уу гэсэн бодолтой байна.

Энэ хүрээнд хоёр, гурван зүйл байгаа юм. Нийгэм чинь энэ цалин хөлстэй холбоотой, тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуудлууд яригдаад байна. Энэ дээр тодорхой хэмжээний орон зайнууд гарах бололцоо байгаа юм уу? Одоо ер нь та хэд юу гэж ойлгоод байна вэ?

Тэр яригдаад байгаа тоног төхөөрөмжийн асуудал ч гэдэг юм уу, бусад урсгал зардал тал дээр хооронд нь зохицуулалт хийж, шийдэл гаргах бололцоо боломж дээр ер нь ямар зүйл байна вэ гэдэг нэг асуудал байна гэж.

Хоёр дахь зүйл, хөрөнгө оруулалтын асуудал дээр бас анхаармаар юм байгаа юм.

Ер нь 80-аас дээш хувийн гүйцэтгэлтэй барилга, байгууламжууд ер нь хэдий хэмжээний байгаа юм бэ? 2026 онд санхүүжих дүн дутуу тавигдсан гэдэг юм уу, тавигдаагүй. Үндсэндээ тодорхой хэмжээний хөрөнгө гаргаад, дуусаагүй үйлдвэрлэлийн барилга бий болгосон. Цаад талдаа тодорхой хэмжээний хэрэгцээ шаардлагууд байгаад байдаг.

Бид ашиглаж чадахгүй янз бүрийн нэр ус өгч байгаад зогсоогоод байгаа юмнууд байна. Энэ дээрээ төрийн холбогдох байгууллагууд нэгдсэн санал, дүгнэлт юмнуудаа гаргаад 80-аас дээш хувийн гүйцэтгэлтэй барилга, байгууламжуудыг ер нь дуусгаж барих тал дээр анхаарал хандуулах ёстой юмнууд ер нь ямар юм байна гэдэг нэг зүйл байгаа юм.

Яагаад үүнийг ярьж байна гэхээр аудитын дүгнэлт... /минут дуусав/

Х.Ганхуяг: Ж.Батжаргал гишүүний микрофон нэмээд өгье.

Ж.Батжаргал: Миний тооцож байгаагаар 300 гаруй тэрбум төгрөгийн юм үлдсэн гэж ойлгогддог. Бодвол тодорхой хэмжээний нэмэгдэл юмнууд авагдсан байлгүй дээ. Одоо энэ ер нь ямар хэмжээний дүн мэдээтэй юм үлдээд байгаа юм бэ? Үүнийгээ нэг яаж шийдэх ёстой юм? Энэ нь нөгөө талдаа эргээд хувийн

хэвшил буюу барилгын аж ахуйнуудаа бид хүнд байдалд оруулаад байгаа зүйл байгаа гэж. Үүнийг ер нь яаж зохицуулж бодох ёстой зүйлүүд байна вэ гэж.

Мэдээж Их Хурлын ажлын хэсэг төсвийн шаардлага, тэр болзол журмуудыг хангасан төсөл, арга хэмжээнүүд төлөвлөгдсөн эсэх гээд юмнуудаа нарийсгаж шүүнэ. Энэ хүрээнд мэдээж буцаагаад энд асуудлууд гарч ирэх юм бол тодорхой хэмжээний бий болсон эх үүсвэрийг тодорхой болзол шаардлага хангасан төсөл, арга хэмжээ рүү шилжүүлэх арга хэмжээнүүдийг хийх ёстой л гэсэн би ийм л бодолтой байна. Энэ дээр нэг тодорхой... /минут дуусав/

Х.Ганхуяг: Хэн хариулах юм? 6 номер.

Ж.Дэлгэржаргал: Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Өмнөх онууд болон эхэлсэн төслүүдтэй холбоотой нэмэлт санхүүжилтийн хүсэлт яамдаас ирээд бид яг аудит руу Сангийн яамнаас өнгөрсөн жилийн 12 сараас эхлүүлээд 8 удаагийн албан бичгээр бүх төслүүдийг магадлал гарсан. Одоо нэмэгдлүүдийг аудитад хүргүүлсэн.

Нийт нэмэгдлийн дүн 194 төслийн 609.0 тэрбум. Өргөн барихаас өмнө Үндэсний аудитын дүгнэлтээр баталгаажуулаад 100 төслийн 194.0 тэрбум ирснийг төсвийн төсөлд бүрэн тусгасан.

Тэгэхээр цаана үлдсэн нь өргөн барихаас өмнө ирж амжаагүй учраас тусгагдаагүй. Өргөн барьснаас хойш Үндэсний аудитын газраас 15 төслийн 23 тэрбумын нэмэгдэл ирснийг Улсын Их Хурал руу Үндэсний аудитын газраас хүргүүлсэн байгаа.

Төсвийн төсөлд тусгасан нийт ажлуудыг дуусах хугацаагаар нь аваад үзэх юм бол

- ▶ 73 хувь нь 2026 ондоо дуусна. 424 төсөл.
- ▶ 19 хувь буюу 110 төсөл нь 2027 онд дуусахаар.

→ Үлдсэн 7 хувь буюу 45 төсөл нь. Эдгээр төсөл 2026 онд шинээр эхэлж байгаа төслүүд 2028 онд дуусахаар байгаа.

Тэгэхээр төсвийн төсөлд тусгасан 579 төслийн 430 нь яг өмнөх онуудад эхэлсэн шилжих хөрөнгө оруулалтууд байгаа.

Тэгэхээр бид нарын хувьд яг шилжих хөрөнгө оруулалтуудыг аль болохоор 2026 онд дуусахаар төлөвлөсөн байгаа. Энэ тусгагдаагүй ажлууд аудитаас ирээгүй нэмэгдэлтэй үлдсэн төслүүд байна гэсэн үг.

Х.Ганхуяг: Тэр цалин хөлстэй нь холбоотой асуулт асуулаа шүү дээ. Урсгал дээр нөөц боломж байгаа эсэх. Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Эхлээд танд баярлалаа. Яг бодлогын төсвийн чиг хандлага өөрчлөлт. Тэр чиглэл рүүгээ явж байгаа. Үүнийг ойлгож дэмжиж байгаад баярлалаа.

Тэгэхээр цалин хөлсний асуудлыг хэдүүлээ ажлын хэсгээ байгуулаад л тэгээд тал талаасаа сууцгаая л гэж бодож байна. Тийм. Тэгээд ажлын хэсэг дээрээс ямар санал гаргах нь вэ? Бид ч бас дахиад эргээд сууя. Сайд нартайгаа эргээд сууя. Тулгамдсан асуудал юу байна. Тэрийгээ эрэмбэлж тавьж байгаад ажил хэрэгч байдлаар Их Хурал дээрээ ярилцаад явцгаая. Одоо ямар буцаалттай нь биш.

Тийм учраас хоёр дахь хэлэлцүүлэг дээр төсвөө үргэлжлүүлж хэлэлцье гэдгээрээ яваад тэгээд дараагийнхаа ажилд орцгоосон нь дээр байх.

Х.Ганхуяг: Ж.Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд албан ажилд томилолттой хөдөө яваа юм билээ.

Ер нь бид хэд ний нуугүй үнэнийг хэлэхэд энэ яриад байгаа асуудлуудыг шийдлийг олъё гэвэл агуулгын хийгээд, бүтцийн нэлээн том шинэчлэлийг хийхгүйгээр явахгүй. Хэдэн тоо хооронд нь гүйлгэж өөрчлөх, шилжүүлэх замаар шийдэх боломжгүй юм билээ.

Тийм учраас “татварын реформ”, энэ төсвийн зарлагын зохистой харьцааныхаа асуудлыг, чиг үүрэг, бүтэц энэ бүх юмтайгаа уялдуулж иж бүрэн авч үзэж хийхгүйгээр бид явахгүй ээ.

Би хараад байгаа юм. Нийгмийн даатгалын энэ төсвийн асуудлыг чинь хараад л мэргэжлээс шалтгаалах өвчин, ажилгүйдлийн даатгал гээд энэ нэг зүйлийг төр өөр лүүгээ татаж авч байх хэрэг байгаа юм уу? Холбогдох хуулиудад нь өөрчлөлт оруулаад ажил олгогчид нь үүрэг хариуцлагыг нь өгөөд тэнд нь хариуцлагыг нь үүрүүлбэл яасан юм.

Х.Ганхуяг: Нэмэх юм уу? Та. Дахиад 1 минут нэмье. Ж.Батжаргал гишүүн дээр.

Ж.Батжаргал: Том юм хийхгүй бол хэдүүлээ энэ юмнаас гарахгүй ээ.

Тийм учраас одоо ер нь хаана хаанаа хариуцлагаа ч сайжруулж, оролцоо, хяналт, энэ бүх юмнуудаа бий болгох ёстой. Үүнийг дагаад хиймээр зүйлүүд их олон байх юм. Та хэд дээр энэ талын судалгаа юмнууд байдаг юм уу? Энэ нэг баахан төрийн өмчтэй компаниуд тойрсон хулгай зэлгий, шахаа ярина. Үгүй тэгвэл энэ олон нийтийн болгох асуудлыг нь шийдэх чиглэлээр 2026 он дээр юу

хийх гээд байгаа юм? Тэрийг дагаж энэ улсын төсөв рүү чинь тодорхой хэмжээний дэм болж орж ирэх юм ер нь юу байгаа юм бэ? Юу төлөвлөсөн юм?

Ийм зүйлүүдээ л хэдүүлээ ярихгүй бол тийм орж ирсэн тоон дээр жижиг өөрчлөлтүүд хийх гэж оролдоод нийгмийн хүлээлтийг давж чадахгүй байна л даа. Яг үнэнийг хэлэхэд.

Х.Ганхуяг: Үг хэллээ. Д.Энхтүвшин гишүүн байхгүй байгаа юм байна. С.Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Одоо зөндөө л удаа хэлсэн. Одоо юу ярих гэж байгааг мэдэж байгаа байлгүй дээ. Б.Жавхлан сайд.

Түрүүн гишүүд хэллээ. Энэ цалин хөлсний хувьд одоо яг яах юм бэ гэдэг юм Засгийн газарт ер нь бодол байна уу? Та хэд ирэх жил ер нь байхгүй. Тэрний дараа жил боломж гарвал гэдэг байдлаараа.

Тэгээд төсвийнхөө 24 хувийн хязгаарыг өөрсдөө оруулж ирсэн Засгийн газар. Тэгээд тэрийг Их Хурал баталсан гээд суугаад байгаа. Зарчмын хувьд зөв болов уу. Урсгал зардлыг тодорхой хэмжээнд хязгаарлах гэж.

Бүтцийг нь аваад үзэхээр манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ч гэсэн энэ дээр нэг дүгнэлт өгмөөр байгаа юм. Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын санг яагаад урсгал зардал руу оруулаад байгаа юм бэ? Улсын төсөв рүү.

Энэ тал дээрээ нэг дүгнэлт өгөөд тавихгүй бол одоо бид өөрөө өөртөө чагтан түгжээд тавьчихаад тэгээд нэмэх боломж байна. Харамсалтай нь 24 хувь. Хуульд 30 хувийн боломж байгаа шүү дээ.

Тийм учраас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний нэг заалтыг аваачаад тэгээд бурхны зарлиг мэт тавьчихаад тэгээд одоо ямар ч боломж байхгүй гэсэн. Гадаа би өдөр гарч уулзаад. Та нар гарч уулзаарай. Тэр багш нар ямархуу байдалтай байж байна вэ. Хасах 5, 10 градусын цементэн дээр хүрдэг. Түүн дээр өдөржин сууцгааж байна. Удахгүй ажил хаялт руугаа орно оо л гэж байна.

Тийм учраас энэ тал дээрээ нэг гарц юм яриад. Ер нь боловсрол гэдэг юм уу, энэ төрийн албанд байж байгаа хүмүүс маань ирэх 4 жилийн хугацаанд, 3 жилийн хугацаанд гэдэг юм уу, ийм харьцааны цалингийн нэмэгдэл яригдана гэдэг бодлогынхоо юмыг оруулж ирэхгүй бол жил болгон шаардаад, нөгөө талд нь байхгүй гэж хэлээд нэг бөөн хэрүүл ам болдог л нэг юм болоод байна л даа.

Тийм учраас энэ тал дээрээ хэдүүлээ тодорхой юуг оруулж ирмээр байна. Би бол тэр төсвийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө дээр өөрчлөлт

оруулаад нэг заалт өөрчлөхөд Засгийн газар өөрөө оруулаад ирэх тийм хуультай шүү дээ. Гишүүдэд тэр төсөв санхүүтэй холбоотой эрх байхгүй.

Тийм учраас Засгийн газар өөрөө ороод ир. Сангийн яам өөрөө санаачлаад оруулаад ир. Тэгээд тэр эх үүсвэрээ алдагдалтай байна уу, юутай байна вэ гэдэг байдлаар ард түмэн ойлгох болов уу гэж бодож байна. Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжээ нэмэх зорилгоор алдагдлын хэмжээ ийм хэмжээнд хүрнэ гэж.

Тэгээд тэр 2 их наяд төгрөгийг хэмнээд болж байсан. Жилийн 6 сараас хойш тендер нь зарлагдаагүй. Тэгээд ийм зардлуудыг доор нь танаад л ирж байсан.

Тэгэхээр төсвийн боломжоо дайчлаад нэг үзээч ээ гэж би бодож байна.

Дээрээс нь санал өгөхөөр ерөөсөө авахгүй юм. Би эрүүл мэнддээ гэхээр бүр ядарсан санал юм даа. Хөөрхий. Нэг Ланд Крузер машины л дүнтэй тэнцэх нэг аймагт. Энд тэнд очихоор баахан мотоцикл ихтэй юм билээ. Багийн эмч нар чинь мотоциклгүй байна. Тэгээд тавихаар байхгүй л гэж байгаа юм.

Тэгэхээр иймэрхүү иймэрхүү байдалтай ер нь санал авах юм уу, авахгүй юм уу, эсвэл сайхан яриулж байгаад тэгээд байхгүй гэж хэлээд... /минут дуусав/

Х.Ганхуяг: С.Эрдэнэбат гишүүнд нэмээд 1 минут өгье.

С.Эрдэнэбат: Ахмадын тэтгэвэр дээр хэлэхэд ажлын хэсэг нь Өргөдлийн байнгын хорооноос би бас нэг ажлын хэсэг гаргаад ахалж байгаа.

Яг хуулиар аваад үзэх юм бол өмнөх оны инфляцаас доошгүй гээд байж байдаг. Тэрний өмнөх оны инфляцын зөрүү гээд 0.5. Нийтдээ бараг 7, 8 орчим, 10 орчим хувиар нэмж байж л энэ хуулийн шаардлага хангах юм билээ. Хуульчилсан, хатуу хуульчилсан шүү дээ. Нийгмийн даатгалын хуульд.

Эсвэл үүнийгээ тэр нийт хувь хэмжээ болон тогтмол мөнгөн дүн гэдэг хосолмол байдлаар шийдэх нэг аргыг Сангийн яамныхан бодож оруулж ирээч ээ. Тэгэх юм бол наадах чинь яг нэг дундыг барьсан шударга зүйл болох юм байна лээ.

Яг одоо бүгдээрээ шударга төлөөд өндөр бага болсон юм болов уу л гэвэл бас үгүй. Үүнийг Гэр бүл, хөдөлмөрийн яам ч гэсэн бүгдийг нь нотолж байгаа. Зарим нь хязгаартайгаар тэтгэврийг нь бага тогтоосон гээд. Тэгээд яг ийм зүйл рүүгээ урагшилмаар байна. Тэгэхгүй бол одоо нэг, хоёрдугаар хэлэлцүүлэг дээр хэдэн тоо асуугаад ингээд ерөөсөө урагшилсан юм байхгүй тэгээд л гацаатай байгаад байна.

Тэгэхээр энэ тал тал дээр Та хэд маань санал оруулж ирж ирээч.

Х.Ганхуяг: Асуулт асуусан юм уу? Санал хэлсэн юм уу? Хэн хариулах юм.

Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Гишүүний асуулт өөрийнх нь ажил мэргэжилтэй олон жил ажилласан байгууллагатай нь холбоотой байдаг байх аа. Ойлгоод байгаа.

Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын сан төсвийн урсгал зардал талд бичигддэг. Ингээд яваад 34 жил болжээ.

Энэ бүртгэлийн асуудлыг нь өөрчилнө гэвэл энэ нэлээн том суурь асуудал яригдана. Энэ дээр бид GOVERNMENT FINANCIAL STATISTICS гээд Олон Улсын Валютын Сан, Дэлхийн банкнаас, OECD /Organisation for Economic Co-operation and Development/-ийн орнуудад баримталж байгаа дараагийн үеийнх нь бүртгэл, тайлагналын энэ систем рүү шилжихээс нааш энэ бол өөрчлөлт орохгүй.

Энэ бол нэлээн нүсэр ажил болно. Төсвийн суурь хууль дээр бараг 80, 90 хувийн шинэчилсэн найруулга хийгдэнэ. Энэ дээр ямар ч байсан Сангийн яам ажлаа эхлүүлсэн байгаа.

Тэгэхдээ энэ бол нэг жилийн ажил биш, хоёр жилийн ажил биш. Ер нь дорр хаяж 4-өөс 5 жилийн ажил болно. Бусад манайтай ижил төстэй болон манайхаас арай жоохон том эдийн цэцэгтэй улс гүрнүүд 4, 5 жил нь бас багадаж байгаа ийм практикууд байгаа.

Тэгэхээр энэ рүүгээ бид зориглоод ямар ч байсан орно.

Тэр 24 хувийн хязгаар ноднин төсөв хэлэлцэж байх үед шинэ Их Хурал дээр эхний төсөв батлагдах үеэр энэ бол маш их гишүүд ийм санаачилга гаргаж Засгийн газарт үүрэг өгсөн шүү дээ. Тэр дагуу Засгийн газраас хавар нэлээн олон гэрийн даалгавар Улсын Их Хуралд өргөн барьсан байдаг. Тэр дунд орсон хязгаарлалт байгаа.

Тийм учраас хэрэв Та санаачилбал бид хэлэлцээд тооцоон дээр нь суугаад явъя.

Түүнээс биш Засгийн газар үүнийг эргээд санаачлах ямар ч боломж байхгүй. Тэрийг худлаа яриад яах вэ.

Санал өгөхөөр авахгүй байна гээд. Улсын Их Хурлын гишүүд санал өгөх бүрэн эрхтэй л дээ. Тэгэхдээ тэрийг төсөвт суулгана гэдэг чинь төсөв өөрөө

хуультай, дүрэмтэй. Төсвийн ерөнхийлөн захирагч нар сайд нараар дамжаад салбар салбарын төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбэ, тусгай хэрэгцээ шаардлагууд дээр нь хангасан зүйлүүд нь эцэстээ хязгаар, нөгөө тоондоо багтаад л орж ирэх ёстой. Ийм системээр төсөв өргөн баригдаад явж байгаа.

Тэр хөдөлмөр, нийгмийн хамгаалалттай холбоотой асуултуудыг яамнаас нь хүн байхгүй юу. Яамнаас нь хүн хариулах нь зөв өө.

Х.Ганхуяг: С.Эрдэнэбат гишүүн тодруулах юм уу?

С.Эрдэнэбат: Үгүй одоо би санаачилж болж байна л даа. Тэр 24 хувийн асуудлыг.

Тэгэхээр уг нь энэ чинь хуулиараа төсөв санхүүтэй холбоотой хэлэлцэж байх үед санаачлах эрх нь Засгийн газартай байгаа.

Тэгэхээр та хэд маань өөрсдөө оруулж ирээд яг энэ тавьж байгаа санал, шаардлагуудыг хүссэн хүсээгүй ийшээгээ тулах л байх л даа.

Тэгэхээр энэ тал дээрээ илүү санаачилбал би зүгээр юм болов уу л гэж бодоод байгаа юм. Нөгөө талд нь магадгүй манай Тогтвортой байдлын зөвлөл юмнаасаа ухарлаа энэ тэр гээд л зүйлүүд ярих байх. Гэхдээ саяын тэр бүртгэлийн асуудал, шилжих асуудал мэдээж цаг хугацаа орох байх. Гэхдээ үзэл баримтлалын хувьд үндсэн концепцын хувьд аваад үзэхэд буруу л гээд л байвал буруу шүү дээ энэ чинь.

Тийм учраас үүнийг заавал одоо тоолоод л 4, 5 жилийн дараа тоолохоо болино гээд л. Тэгээд л тэр 24, 30 хувь гэдэг чинь бүгд хамааралтай. Би бол амьхандаа та хэдийг асуудлаас гарахад ийм боломжууд байна л гэж хэлээд байгаа юм.

Х.Ганхуяг: Санал хэллээ. Да.Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Та бүхэнд оройн мэнд хүргэе.

Аудит байгаа учраас би хоёр, гурван юм асуух гээд байна. Уг нь одоо энэ чинь Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай орлого, зарлагын асуудлыг л ярих гээд байгаа юм.

Өмнө Хууль зүйн байнгын хороон дээр уг нь хэлсэн юм. Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргыг дуудаадхаач, ойр зуурын асуулт байна гээд. Тэдний тэр авлигын асуудал яригддаг. Тэгээд тэр асуудлуудыг нь одоо уг нь ярья гээд. Энэ Эрүүл мэндийн сайд нь би бол оруулж ирэх байх гэж бодсон юм. Эрүүл мэндийн сайдад Нийслэлийн эрүүл мэндийн газар дээр болж байгаа авлигын асуудлуудыг хэлсэн. Одоогоор ямар ч хариу шийд байхгүй байгаа юм.

Тэгэхээр 2024 оны Засгийн газрын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт надад энд байгаа юм. Тэгээд энэ дээр би өмнө нь төсөв хэлэлцэж эхлэх үед чуулган дээр аудитынхнаас асууж байсан. 12 их наяд төгрөгийн алдаа дутагдлын асуудал байна.

- ▶ Энэ дээр хэн ямар хариуцлага хүлээж ямар үр дүнд хүрсэн бэ?
- ▶ Алдаа дутагдал арилсан уу?
- ▶ Та нар өөрсдөө ямар акт өгсөн юм?
- ▶ Альныг нь төсвийн ерөнхийлөн захирагчид нь мэдэгдсэн юм?
- ▶ Альныг нь хуулийн байгууллагад шилжүүлсэн юм?
- ▶ Ямар үр дүн гарсан юм?
- ▶ Хэн хариуцлага хүлээсэн юм гээд.

Одоо жишээлэхэд Дарханы төмөрлөгийн үйлдвэр гээд 42.1 их наядын зөрчил байгаа юм. 42.1 тэрбум төгрөг. Тэгтэл одоо энэ Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг чинь бид хувийн хэвшлээс дээрэмдэж авчирч байгаад, төрийн өмчийн болгож байгаад авсан төрийн өмчит компани.

Тэгээд үүнийг хэн захирлыг нь томилсон бэ гэх юм бол Монгол Ардын намын Ерөнхий нарийн бичгийн дарга нэг хуурай дүүгээ аваачаад тавьсан.

- ▶ Энэ бол аалзны тор.
- ▶ Энэ бол авлигалын сүлжээ.

Тэгээд тэнд тавигдсан нөхөр нь ямар ч металлургийн ч юм уу, хүнд үйлдвэрлэлийн мэдлэг, туршлага байхгүй. Нэг цүнхчин нөхөр очоод 42.1 тэрбум төгрөгийн алдаа дутагдал гаргаад сууж байна.

Гэх мэтчилгээр төсвийн ерөнхийлөн захирагч болгонд алдаа дутагдлыг нь та нар бичээд өгсөн энэ 2024 оны санхүүгийн тайлангийн алдаа дутагдлууд дээр чинь хэн ямар хариуцлага хүлээсэн юм бэ?

Бид одоо 33 их наядын төсөв батлах гээд сууж байна.

Тэгээд бид батлаад байдаг. Алдаа дутагдал гараад байдаггүй байж болохгүй юу? Алдаа дутагдлаа засаад цаашаа явдаг болмоор байна.

Өнгөрсөн хугацаанд хэн ямар хариуцлага хүлээж, ямар алдаа дутагдлаа засаж сайжруулсан бэ гэдгийг одоо энэ 2025 оныхыгоо больё гэхэд 2024 оныхыг энд ярьчихаад тэгээд бид цаашлахгүй бол “элсэн дээр дуслаар ус асгаж байгаа” юм шиг л энэ Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалт асгараад яваад байна.

Тэгээд 60, 70 хувь нь урсгал зардал.

Тэгээд энэ дээр хариуцлагын тал дээр аудитаас хариулт авъя.

Х.Ганхуяг: Аудитаас 4 номер уу? 4 номер.

З.Цэдэнжав: Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав.

Төрийн аудитын байгууллага 2024 оны Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд сая хавар аудит хийгээд дүгнэлтээ гаргасан. Нэлээдгүй зөрчил, дутагдал илэрсэн. Төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр зөвлөмжийг өгч, хязгаарлалттай дүгнэлтийг өгөөд, ерөнхийлөн захирагч бүрээр бид зөвлөмжүүд өгсөн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тодорхой албан тушаалтнуудад хариуцлага тооцуулахаар саналаа хүргүүлсэн байгаа.

Бид яг одоо санхүүгийн тайлангийн завсрын аудитаа хийгээд эхэлж байна. Энэ үед аудитын шийдвэрийн хэрэгжилтийн талаар нэгдсэн дүн гарна. Төсвийн дараагийн хэлэлцүүлгийн үед гишүүнд энэ талаар тодорхой мэдээллийг өгье.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитаар Улсын Их Хуралд хоёр асуудал толилуулсан.

- Монгол Улсын Засгийн газарт 7,
- Сангийн сайдад 4,
- Монгол Улсын Шадар сайд буюу Эдийн засаг, хөгжлийн сайдад 1,
- Төсвийн ерөнхийлөн захирагчид 2 зөвлөмж өгсөн.

Зөвлөмжийн биелэлт 75.4 хувийн байна гэж 2026 оны төсөвт дүгнэлт өгөх аудитын дүнгээр гарсан байгаа.

Х.Ганхуяг: Да.Цогтбаатар гишүүний микрофоныг нээж өгье.

Да.Цогтбаатар: 2025 оны 9 сарын 15-нд намрын чуулган нээгээд төсвийн асуудал хэлэлцэж эхлэх үед аудитынхныг сууж байхад би яг энэ асуултаа асууж байсан юм.

- ▶ Ямар хүнд ямар хариуцлага тооцуулах саналаа та нар хаана хүргүүлсэн бэ?
- ▶ Ямар үр дүнд хүрсэн бэ?

Асуултаа ойлгоогүй байна. Та нар Төсвийн байнгын хороон дээр орж ирээд дэлгэрүүлээд асуугаадхаач, түүнд чинь дэлгэрэнгүй хариулъя гэсэн. Одоо хариулж байгаа нь дахиад араас нь хүргүүлье гэдэг юм яриад байх юм.

Аудитын 4 номер дээр сууж байгаа дарга шинэ дарга байж магадгүй. Гэхдээ ажилтайгаа хурдан танилцмаар байна. Та нарыг танилцах дадлага хийх гэсээр байтал цаг хугацаа урсаж өнгөрөөд байна.

Аудитын 5 номер дээр сууж байгаа дарга дээр би яг энэ асуудлыг чуулган дээр ойлгоогүй байна, та нар. Би яг ингэж асуусан гэдгийг чинь хэлээд орхисон. Тийм биз? Тэгээд одоо дахиад хариулт байхгүй.

С.Магнайсүрэн дарга ч гэсэн аудитыг хариуцлагагүй авч явна гэж байгаа бол бас л болоогүй. Хариуцлага үнэхээр яригдах болоогүй байна, Монголд.

Х.Ганхуяг: Гишүүний асуултад гүйцэд хариулна шүү. 5 номер хариул.

Д.Энхболд: Санхүүгийн аудитын газрын эрхлэх асуудлынх байгаа. Манайх болохоор гүйцэтгэлийн аудит.

Х.Ганхуяг: 4 номер.

3.Цэдэнжав: Аудитын шийдвэрийн хэрэгжилт, зөвлөмжийг биелүүлэх хугацаа 9 сарын 30-наар байгаа. 9 сарын 30-наарх шийдвэрийн биелэлт манай дээр одоо ирээд нэгтгэгдэж байгаа. Үүнийг танилцуулна.

Бид шинэ бүтэц зохион байгуулалтаар аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа Их Хурлаас тавьж байгаа гишүүдийн шаардлагын дагуу аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх нэгжтэй болсон. Энд тодорхой ажлууд хийгдээд, үр дүнгүүд гараад явж байгаа. Энд Их Хурлын гишүүд, мөн шалгагдагч байгууллагуудын үйл ажиллагаанд бид бодитой дүгнэлт хийгээд удахгүй танилцуулга хүргүүлнэ. Танд.

Х.Ганхуяг: Б.Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

Б.Мөнхсоёл: Асуулт гэхэд зөв үү, буруу юу. Мэдэхгүй. Ямар ч байсан бүгдээрээ Төсвийн тухай хуулийн хэлэлцүүлгийн хоёр дахь үе шатад ирсэн байна.

Тэгээд улс даяараа ажил хэрэгч байхад жоохон амаргүй ийм үе ирж. Нөгөө талдаа төрийн албан хаагчдыг загнахад амархан юм шиг мөртлөө нөгөө ганц гол бас ийм байхад шалтгаалж байгаа нэг хүчин зүйл нь улс төржилт гэдгийг хэн хүнгүй мэдэж байгаа.

Үүний цаана манай Монгол Улсын сонгуулийн шударга байдал энэ тэр гээд олон юм ярьж болно. Бас энэ улс төрийн салбарт 10 жил болж байгаа хүний хувьд хэн нь хэнийгээ загнах вэ гэдэг бас хэцүү байдаг юм байна гэдгийг энэ дотор орж ирээд ойлгоод явж байгаа хүний нэг байна.

Тэгээд бид төсвийн реформыг хийхээс өөр аргагүй болсон. Төсөв өөрөө хөгжлийн бодлого, Засгийн газрын жилийн болон ер нь одоо тэр 5 жилийн хөгжлийн бодлогын төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл гэж бүгд мэдэж байгаа.

Одоо бид эргээд харахад онцгой байдлынхаа ажилчдыг, гал түймэртэй багаж хэрэгсэлгүй, зохих ёсны хувцас, тоног төхөөрөмж хангалттай бишээр тулалдахад хүрсэн ийм байдалд байгаа шүү дээ. Монголд. Тэгээд энэ асуудлаа шийдье гэхээр зээлээр гээд ер нь яривал маш их асуудал байгаа. Ингээд өм цөм яриад байна. Гишүүн болгон өөрсдийнхөө илүү хардаг гэх юм уу, тэр газраас гарч ирсэн салбарынхаа тэр төлөө л болоод явж байна. Нэг талдаа зөв боловч нөгөө талдаа Монгол Улс нэг зангидсан гараар төсөв базах ёстой гэдэг тэр хэсэг хаягдаад байгаа юм шиг санагдаж байна.

Зөвхөн Сангийн яам дээр биш. Энэ хэсэг бас Эдийн засаг, хөгжлийн яам дээр ирэх ёстой. Тэр ажил хангалттай хийгдэхгүй байна уу даа гэсэн эмзэглэл байна.

Мэдээж засаг байн байн солигдоод байгаа. Тэрийгээ дагаад төрийн албан хаагчид нөлөөлж байгаа учраас шалтаг шалтгаан байна.

Зүгээр тодорхой юм хэлэхэд санал гэж хэлэх үү? С.Эрдэнэбат гишүүн ч хэлээд байгаа. Олон гишүүд бас яг адилхан санаатай байгаа шүү дээ. Заавал энэ сэдвийг барьж аваад л ярихгүй байгаа болохоос биш. Гишүүн бүр л төрийн албан хаагчдын, тэр тусмаа багш нарын, эмч нарын цалинг нэмэх, тэтгэврийг нэмэх ийм л сонирхолтойтэй байгаа.

Нөгөө талдаа татвар төлөгчдөө бас бодох ёстой. Бизнесийнхээ салбарыг гээд олон хүчин зүйлсийг бодох хэрэгтэй болоод байгаа юм.

Ямар ч байсан багш нарынхаа цалинг 25 хувь биш юм гэхэд 10-аас 15 хувь нэмэх боломж байна гэж энэ төсөвт харж байгаа. Энэ ажил дээрээ ажиллая гэж Сангийн сайд намайг асуухаас өмнө дуугарлаа гэж ойлголоо.

Тэгээд дараагийн хэлэлцүүлгээс өмнө энэ цалин нэмэгдээд ороод ирэх байх гэсэн хүлээлт үүслээ шүү л гэж хэлье.

Х.Ганхуяг: Монгол Улсын 2026 оны төсвийн төслүүдэд холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу?

Д.Үүрийнтуяа гишүүнээр тасаллаа. Д.Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: 2026 оны төсвийн төсөл өнгөрсөн жилийн миний хувьд Их Хурлын гишүүн болоод нэг жил суухдаа 4 удаагийн төсөвтэй танилцлаа. Тодотголтой нийлээд.

Энэ орж ирж байсан төслүүдээс макро эдийн засгийн бодлогын хувьд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт, мөн төсвийн тусгай шаардлагуудыг хангах чиглэлд илүү ахиц гарсан төсөв болжээ.

Гэхдээ бидэнд энэ дотор ярих асуудал олон байна. Өнөө маргаашаа аргацаасан байдлаар орлогоо зөвхөн зэс, нүүрснээсээ төлөвлөөд, зардлаа яг энэ бүтцээрээ аваад яваад байх юм бол бурхан ивээж дотоодын нийт бүтээгдэхүүн өсөх болтугай гээд залбираад суухаас өөр арга хэмжээ авах боломжгүй болж эхэллээ.

Тийм учраас төсвийн эрс шинэчлэлийг хийх зайлшгүй шаардлага байна. Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, төсвийн бодлогоо бид өөрчлөх ёстой. Ялангуяа урсгал зардлын ангиллыг дотор нь задалж авч үзэж, өөрчлөлт хийх, төсвийн орлогын эх үүсвэрийг татварын бус орлогоо нэмэх зэрэг энэ асуудлууд дээр бодлогын өөрчлөлтийг хийгээч ээ гэж Сангийн яам, Сангийн сайдаас хүсэх байна. Нэг.

Хоёрдугаарт, асуултад хариулахад түрүүн навигацийн орлогыг Сангийн сайд баталдаггүй гээд хэн хариулав.

М.Санжаадорж дарга аа, 2024 оны Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлт, Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын 2024 оны А/78, А/71 дүгээр хамтарсан тушаалаар орлогын төлөвлөгөөг 21.9 тэрбумаар бууруулж, 336.0 тэрбумаар өөрчлөн баталсан гэдэг дүгнэлт байна.

Би худлаа яриад байгаа юм биш ээ. Та Байнгын хороон дээр мэдээллээ зөв өгөх хэрэгтэй. Энэ таны үүрэг.

Энэ асуудлыг ч гэсэн бид энэ төсвөөс гадуур төсөв байгаа асуудал дээр анхаарах ёстой асуудлын нэг нь энэ. Нөгөөтээгүүр бид энэ татварын хуулийг тэр нэг хувь хүртэл хөрөнгө оруулалтын зардлыг тооцох тэр хуулийн өөрчлөлт бол нэг талдаа зайлшгүй төсвийн хөрөнгөөр хийж чадахгүй байгаа зүйлээ хийе гэж бодож дэмжсэн. Өнөөдөр гүйцэтгэл гарах гэж байгаа нөхцөл байдлыг эргээд харахаар татварын орлого өөрөө эргээд улсын төсөвт ордог. Төсвийн орлогыг хэн төлөвлөж зарцуулдаг вэ гэхээр төлөвлөх, түүнийг батлах эрх нь Улсын Их Хуралд хадгалагдаж байгаа шүү дээ. Засгийн газрын төлөвлөөд ороод ирснийг батлах. Гэтэл үүнээс гадуур дахиад тэр орлогын эх үүсвэрийг зарцуулдаг субъект үүсэх гээд байна л даа. Батлахгүйгээр.

Тэгэхээр энэ асуудлаа нэгтгэж Сангийн яамны хувьд, бодлогын хувьд журамлаач ээ. Ялангуяа төрийн өмчит компаниудын татварын нэг хувийн асуудлыг.

Буцаах тухай асуудлыг зарим гишүүд хөндөж байх шиг байна. Төсвийн төслийг.

Тэгэхээр яг одоо өнөөдөр энэ бодлогын хувьд, хууль эрх зүйн хувьд өөрчлөлтийг хийж чадахгүйгээр буцаалаа гээд энд сайжрах зүйл байхгүй. Үүнээсээ илүү алдагдал, үүнээсээ илүү эрсдэлийг хүлээх нөхцөл байдал байна.

Тийм учраас төсвийн бодлогыг тогтвортойгоор, эдийн засагт хямрал багатайгаар, ард түмний амьдралд хямрал багатайгаар өөрчлөх, боловсронгуй болгох энэ хөтөлбөр, энэ арга хэмжээгээ цогцоор нь авч хэрэгжүүлэх нь Сангийн яамны хийх гол ажил болоод байна шүү. Энэ бол Эдийн засаг, хөгжлийн яам. Ганц Сангийн яам гэлтгүй Засгийн газрын түвшинд анхаарах асуудал болоод байна шүү гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Нөгөө талаар бид энэ хийж дуусаагүй байгаа хөрөнгө оруулалтын ажлуудыг мөнгийг нь тавихгүй хасчхаад шинээр ажил эхлүүлээд байгаа юм. Шинэ эхэлж байгаа ажил нь дахиад л 3, 4 жил төсвийг нь хуваасан. Гэтэл хүссэн хүсээгүй 2 жил болоод дахиад магадлал хийлгэх болно.

Төр өөрөө төсвийн бодлогоороо энэ магадлалыг дэмжээд байгаа юм. Үүнийгээ болиоч ээ гэдгийг хэлмээр байна.

Х.Ганхуяг: Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд би өөрөө танилцуулъя.

Монгол Улсын 2026 онд төсвийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгүүдийг хийж дууслаа.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Хоёр.Дэд хорооны даргыг сонгох тухай асуудал

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэж эхэлнэ.

Ажлын хэсэг явж байж болно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10-т дэд хорооны даргыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар гишүүдийн олонхын саналаар сонгох бөгөөд Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг цөөнхийн бүлгийн гишүүдээс, хэрэв цөөнхийн бүлэг байгуулах гишүүдийн тоо хүрэхээргүй бол цөөнхийн гишүүдээс сонгоно гэж заасан.

Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарыг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргад нэр дэвшүүлсэн албан бичиг ирүүлсэн байна.

Албан бичиг Та бүхэнд уншиж танилцуулъя.

“Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга томилуулах тухай”.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10 дахь заалтын дагуу Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарыг томилж өгнө үү гээд бүлгийн дарга О.Цогтгэрэлээс ирсэн байна.

Гишүүдийн ирц хангалтгүй байгаа тул тус асуудлыг дараагийн Байнгын хорооны хуралдаанаар авч хэлэлцье.

Өнөөдрийн хуралдааныг хаалаа. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 28 минут үргэлжилж, 17 цаг 50 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД